



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • VIII • № 36

**Н.БАЯРТСАЙХАН:
ТӨЛБӨРИЙН
СИСТЕМ ДЭЛХИЙН
ЖИШИГТ ХҮРНЭ**

**ҮНДСЭН
ХУУЛЬ БОЛОН
ТӨВ БАНКНЫ
ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТ**

**АЛТНЫ ҮНЭ
СҮҮЛИЙН 6
ЖИЛИЙН ХАМГИЙН
ӨНДӨР ТҮВШИНД
ХҮРЛЭЭ**



ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС: ГУЛУУЗ МӨНГӨ

ХАЛХЫН ГОЛ 80 ЖИЛ

*Халхын голын 1939 оны байлдааны ялалтын 80 жилийн
ой тохиоёж буйтай холбогдуулж, "Халхын гол 80 жил"
дурсгалын зоосны худалдаанд гаргаж байна.*



Зоосны нэр: Халхын гол 80 жил

Зоосны нэрлэсэн үнэ: 5000 төгрөг

Металл: 999 сорьцтой мөнгө

Жин: 31,1 грамм

Хэмжээ: 39 мм

Зоосны худалдан борлуулах үнэ: 300,000 төгрөг

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Санхүүгийн боловсрол олгох
1870 багшийг чадавхжуулна

4

Ярилцлага:

ХУУДАС

Н.Баяртсайхан: төлбөрийн
систем дэлхийн жишигт хүрнэ

6

Асуулт, хариулт:

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага
хурлаас ... (2019.08.29)

11

Нийтлэл:

ХУУДАС

Америкийн Нэгдсэн Улсад
хараат бус төв банк хэрэгтэй

18

Инфографик:

ХУУДАС

Төв банкны хараат бус байдлыг
Үндсэн хуулиндаа тусгасан улс
орнууд

20

Монголбанкны**мэдээлэл:**

ХУУДАС

Монголбанк он гарснаас хойш
9.6 тонн алт худалдан авлаа

22

Монголбанк**юу хийдэг вэ?:**

ХУУДАС

М.Нургул: Эдийн засгийн
тогтвортой байдалд хувь хүний
санхүүгийн сахилга бат чухал
үүрэгтэй

25

Дэлхийн эдийн засаг:

ХУУДАС

Алтны үнэ сүүлийн 6 жилийн
хамгийн өндөр түвшинд хүрлээ

28

Банкир:

ХУУДАС

Б.Жавхлан: Үндсэн хуульд Төв
банкны бие даасан байдлыг
тунхаглах нь маш чухал

30

Мөнгөн тэмдэгтийн**түүх:**

ХУУДАС

1994 оны гүйлгээний зоосон
төгрөг болон цаасан мөнгө

33

Судалгаа:

ХУУДАС

Үндсэн хууль болон Төв банкны
эрх зүйн зохицуулалт

34

Мэдээлэл:

ХУУДАС

Төлбөр тооцооны систем олон
улсын түвшинд хүрлээ

39

Санхүүгийн боловсрол олгох 1870 багшийг чадавхжуулна

2019.08.06

Монголбанк “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дэмжих зорилгоор ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт багтсан санхүүгийн мэдлэг олгох, “Бизнес судлал” хичээлийг заах 1870 багшийг чадавхжуулахад анхаарч, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттай хамтран ажиллаж байна. БСШУСЯ-аас 2019-2020 оны хичээлийн шинэ жилийг угтаж, Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилгоор үндэсний хэмжээнд 550 сургагч багш бэлтгэх сургалтыг эхлүүлээд байгаа билээ.



Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хамтын ажиллагааны бүлгийн ээлжит хурал болов

2019.08.08



Ээлжит хуралд Монголбанк, СЗХ, Санхүүгийн мэдээллийн алба, Азийн Хөгжлийн банк, Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг олон улсын байгууллага, Австрали, АНУ, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, Япон зэрэг улсын Элчин сайдын яамны төлөөлөл оролцов. Хурлаар Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн мэдээллийн албанаас Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллагын жилийн хуралд оролцох бэлтгэл ажил, Харилцан үнэлгээний техникийн хэрэгжилтийг сайжруулах тайлангийн явц, өмнөх хурлаас хойш хэрэгжүүлсэн ажлаа танилцуулж, тогтолцоог хөгжүүлэх зорилгоор олон улсын байгууллага, гадаад улс орны тусламжийг хэрхэн оновчтой хэрэгжүүлэх талаар санал солилцов.

Банкны салбарын хангайн бүсийн удирдах ажилтны зөвлөгөөн болов

2019.08.12

Монголбанкнаас 3 дахь жилдээ зохион байгуулж буй банкны салбарын удирдах ажилтны хангайн бүсийн зөвлөгөөн наймдугаар сарын 8-10-нд Орхон аймгийн төв Эрдэнэт хотноо боллоо. Энэ удаагийн хэлэлцүүлгээр мөнгөний бодлогын шинээр хэрэгжүүлж буй арга хэрэгслийн үр дүн, цаашдын нөлөө болон банкны хяналт шалгалтын олон улсын стандарт, түүнийг нэвтрүүлж хэрэгжүүлэх тухай түлхүү ярилцав. Эдгээр сэдвийн дор үндсэн хэлэлцүүлгээр Монголбанкны Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир “Эдийн засаг, банкны салбар: Үр дүн, сорилт, сургамж”, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа “Мөнгөний бодлогын асуудлууд”, Хяналт шалгалтын газрын захирал Н.Батсайхан “Банкны эрх зүйн шинэчлэл, хяналт шалгалтын чиг хандлага, цаашдын хамтын ажиллагаа” сэдвээр илтгэл тавьж, хэлэлцүүлэв. Энэ зөвлөгөөн нь банкны салбарын орон нутаг дахь боловсон хүчнийг шинэ тутмын мэдээллээр хангах, чадавхжуулахад чухал ач холбогдолтой.



Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөл хуралдав

2019.08.13



Хуралдаанаар Австрали Улсад 2019 оны 8 дугаар сард зохион байгуулагдах Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагын 22 дахь удаагийн жилийн уулзалтад Монгол Улсыг төлөөлөн оролцох бүрэлдэхүүнтэй уулзаж, Монгол Улсын тайланг амжилттай хамгаалах зөвлөмж, чиглэл өглөө. Мөн холбогдох байгууллагуудаас 2019 оны эхний хагас жилд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээтэй танилцаж, цаашид авах шаардлагатай арга хэмжээг тусгасан зөвлөмж гаргахаар шийдвэрлэв.

“Fitch on Mongolia 2019” форумыг зохион байгууллаа

2019.08.22

Олон улсын зээлжих зэрэглэлийн Фитч агентлаг “Fitch on Mongolia 2019” Улаанбаатар хотод зохион байгууллаа. Форумын үйл ажиллагааг Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нээж, Монголбанк, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон санхүүгийн байгууллагын бусад төлөөллүүд “Монгол Улсын эдийн засаг, банкны салбарын төлөв байдал ба бодлогын тулгамдсан асуудлууд” болон “Уул уурхайн секторын төлөв байдал” сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлэв. Түүнчлэн Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өнөөгийн үнэлгээ болон цаашид зээлжих зэрэглэлийг дээшлүүлэх хүчин зүйлсийн талаар мэдээлэл өгөв.



Макро зохистой бодлогын чиглэлээр олон улсын сургалт зохион байгуулав

2019.08.26



Монголбанк Зүүн өмнөд Азийн төв банкуудын холбоо (ЗӨАТБХ)-ны Судалгаа, сургалтын төв (The SEACEN Centre)-тэй хамтран мөнгөний бодлого, макро зохистой бодлогын мэргэжилтнүүдэд зориулсан “Санхүүгийн мөчлөг ба хямрал” сэдэвт сургалтыг 2019 оны 8 дугаар сарын 26-30 өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгууллаа. Тус сургалтад Ази Номхон далайн бүс нутгийн 10 орны төв банкны төлөөлөл оролцсон юм. Сургалтаар санхүүгийн мөчлөгийн шинж чанар, шалтгаан болон эдийн засагт үзүүлэх нөлөө, бодлогын боломжит хариу үйлдлийн тухай авч үзлээ.

Н.БАЯРТСАЙХАН: ТӨЛБӨРИЙН СИСТЕМ ДЭЛХИЙН ЖИШИГТ ХҮРНЭ



Үндэсний төлбөрийн системийн шинэчлэлийн талаар Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхантай ярилцлаа.

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ УДИРДАХ, ЗОХИЦУУЛАХ, ХЯНАХ НЬ АЛИВАА ТӨВ БАНКНЫ ҮНДСЭН ҮҮРГИЙН НЭГ. ТҮҮХЭН ЗАМНАЛААС ЯРИАГАА ЭХЛЭХ НЬ ЗӨВ БОЛОВ УУ?

Монгол Улсын төлбөрийн системийн дэд бүтцийн шинэчлэлийн ажлыг Монголбанкны үе үеийн удирдлагууд шат дараалалтайгаар хэрэгжүүлж иржээ.

Монгол Улсын Банкны тухай хуулийг 1991 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр батлан гаргаснаар Монгол Улсад Төв банк, арилжааны банк гэсэн 2 шатлал бүхий банкны тогтолцоо бүрэлдэн тогтож, арилжааны банкны хэм хэмжээ, эрх, үүргийг уг хуулиар зохицуулах болов. Төв банк (Монголбанк)-ны тухай хууль 1996 онд батлагдсанаар банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах Монголбанкны үйл ажиллагааг зохицуулжээ.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 1995 онд батлагдаж, бэлэн бус төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, чек, вексель, төлбөрийн картаар гүйцэтгэж байна.

Үүний дараа Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгээр төлбөр тооцооны системийн шинэчлэлийн анхны томоохон төслийг 2002-2006 онд хэрэгжүүлж Монголбанкны төлбөр тооцооны одоогийн сүлжээ, дэд бүтэц, Үндэсний цахим гүйлгээний төв (ҮЦГТ) байгуулагдсан байна. ҮЦГТ нь Монгол улсын төлбөрийн системийн оролцогч хоорондын бага дүнтэй төлбөр болон картын гүйлгээг боловсруулж, мөнгөн хөрөнгийн урсгалыг баталгаажуулж буй чухал ач холбогдолтой төв юм. Монголбанкны ҮЦГТ 2004 онд байгуулагдсанаар бага дүнтэй гүйлгээний шилжүүлгийн цахим системийг, 2010 онд банк хоорондын картын нэгдсэн сүлжээг

тус тус нэвтрүүлж, 2014 онд бага дүнтэй төлбөр тооцоог 24 цагаар тасралтгүй дамжуулж эхэлсэн нь төлбөрийн аюулгүй байдлыг сайжруулж, хурдыг нэмэгдүүлэн, эрсдэлийг бууруулав. Түүнчлэн, өмнө нь их дүнтэй болон бага дүнтэй кредит шилжүүлгийг нэг системээр дамжуулан боловсруулж байсан бөгөөд Монголбанк 2009 онд их дүнтэй төлбөрийг бодит цагийн горимоор гүйцэтгэх төлбөр тооцооны систем (RTGS) буюу Банксүлжээ системийг нэвтрүүлж, их дүнтэй бүх төлбөрийг шинэ системээр дамжуулж байна.

Мөн төлбөр тооцооны эрхзүйн орчныг шинэчлэх ажлын хүрээнд хэрэгжүүлсэн чухал ажлын нэг нь 2017 оны 5 дугаар сард батлуулж, 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн Монгол Улсын “Үндэсний төлбөрийн системийн тухай хууль” зүй ёсоор орно. Энэ хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг

зохицуулах зорилготой бөгөөд Үндэсний төлбөрийн системийн шинэчлэлийн үйл ажиллагаанд цоо шинэ хуудас нээж өгч байгаа билээ.

Монголбанк Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийг 2016 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Шат дараатай авч хэрэгжүүлсэн эдгээр томоохон ажлын үр дүнд манай улсын Үндэсний төлбөрийн системийн шинэчлэл улам бүр гүнзгийрч байна.

ТА МОНГОЛБАНКНЫ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛ” ТӨСЛИЙН ТАЛААР ДУРДЛАА. ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЯМАР АЖИЛ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР АЖИЛЛАЖ БУЙ ТАЛААР АРАЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ЯРЬЖ ӨГНӨ ҮҮ?

Энэ төслийн гол зорилго нь санхүү, төлбөр тооцооны системийн орчин үеийн чиг хандлага, цахим технологи дээр үндэслэн, дэлхийн шилдэг техник технологийг ашиглан Үндэсний төлбөрийн системийг цоо шинэ түвшинд гаргахад оршино.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд Монголбанк нь Үндэсний цахим гүйлгээний төвийн сүлжээний техник хангамж болон нөөц дата төвийг шинэчлэх, үндсэн сүлжээг өргөтгөх, банк хоорондын их дүнтэй гүйлгээний RTGS системийг шинэчлэх, банк санхүүгийн байгууллагуудад цахим гарын үсгийн дэд бүтцийг бий болгох

ажлыг бүрэн хийж гүйцэтгэв.

Дараагийн үе шатанд ҮЦГТ-ийн үндсэн дата төвийг шинэчлэх, банк хоорондын бага дүнтэй гүйлгээний систем (АСН +) шинээр суурилуулах, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон Төв банкны арилжааны системийг шинээр худалдан авах, үндэсний төлбөрийн ₮ картыг шинэчлэх, чип/зайнаас уншдаг технологид шилжүүлэх зэрэг ажлыг эхлүүлээд байна.

Үүнээс гадна Төв банкны суурь бүртгэлийн болон дотоод удирдлагын систем нийлүүлж, суурилуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг зарлаж, нийлүүлэгч компанитай 2019 оны 6 дугаар сард хамтын ажиллагааны гэрээ байгуулж, ажлыг эхлүүлээ.

МОНГОЛБАНКНЫ ҮЦГТ, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЦААШДЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР ТОДРУУЛНА УУ?

Монголбанкны ҮЦГТ-ийг Дэлхийн банкны төслийн хүрээнд банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах, банк хоорондын төлбөр тооцооны хөгжлийг дэмжих үндсэн зорилготойгоор 2004 онд анх байгуулжээ. Байгуулагдсан цагаас хойш Монголбанкны ҮЦГТ нь манай улсын банк, санхүүгийн байгууллага дундын өдөр тутмын бага дүнтэй төлбөр тооцоог баталгаатай, нууцлалын өндөр түвшинд дамжуулж буй гол төв болон хөгжөөд байна. Хүмүүс тэр бүр анзаардаггүй хэдий ч иргэд, байгууллага бүр бага дүнтэй буюу 3 сая төгрөгнөөс бага дүнтэй гүйлгээг нэг банкнаас өөр банкинд шилжүүлэх, нэг байгууллагаас

нөгөө байгууллагад шилжүүлэх эсвэл картын төлбөр тооцоо гарах бүрт ҮЦГТ-ийн дэд бүтцээр дамжиж, мөнгөн хөрөнгийн баталгааг нь Монголбанкинд байрлах арилжааны банкуудын харилцах дансаар дамжуулан хангадаг.

Монголбанкнаас төлбөр тооцооны системийн ирээдүйн хөгжлийн талаар баримталж байгаа бодлого, стратегийг хэрэгжүүлэхэд ҮЦГТ-ийн дэд бүтэц болон хүний нөөцийн чадавхийн хөгжил чухал ач холбогдолтой байна.

Бид ҮЦГТ-ийн дэд бүтэц, хүний нөөцийн чадамжийг сайжруулах, тус төвийг цаашид бэхжүүлэх зорилгоор АХБ-ны төслийн дэмжлэгээр ҮЦГТ-ийн шинэ байрыг барих, техникийн шинэчлэл хийх ажлыг эхлүүлээд байна. Монголбанкны ҮЦГТ-ийн шинэ барилга баригдаж, 2020 онд ашиглалтад орсны дараа бид төлбөр тооцооны системийн орчин үеийн хамгийн тэргүүний шаардлагад нийцсэн мэдээллийн технологийн иж бүрэн дата төв, банк дундын сүлжээний нууцлал аюулгүй байдлыг хянаж, халдлагаас сэрийлэх мэдээллийн аюулгүй байдлын дата төв зэргийг байгуулах болно.

Сүүлийн үед төлбөр тооцооны систем хурдан хөгжиж байгаа, мэдээллийн технологийн хэрэглээ өргөжиж байгаа зэргээс хамааран мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын талаар хөндөж ярих боллоо. Энэ талаар мэдээлэл өгнө үү?

Ер нь төлбөрийн систем гэдэг бол улс бүрийн хувьд онцгой ач

“Засгийн газраас хэрэгжүүлж буй зарим төрлийн төрийн үйлчилгээний төлбөр тооцоог иргэдэд хүргэхэд Монголбанк ҮЦГТ-өөрөө дамжуулан оролцдог. Эдгээр үйлчилгээг иргэдэд хүргэхэд Монголбанк, Сангийн яам болон төрийн бусад байгууллагатай хамтран шат дараалалтай арга хэмжээ авч, аль болох түргэн шуурхай, чирэгдэлгүй байхаар зохицуулан ажиллаж байна. Монголбанк нь Төрийн үйлчилгээний төлбөр тооцоог цахимжуулах ажлыг эхлүүлж, үүнд нийцүүлэн хууль эрх зүйн орчны зохицуулалтыг бий болгож, өөрийн системд програм хангамжийн хөгжүүлэлтийг хийж, төрийн үйлчилгээний төлбөр тооцоог дамжуулан гүйцэтгэх дэд бүтцийг бий болгоод байна.”

холбогдолтой, аюулгүй байдлыг чухалчлан хангаж байх ёстой онцгой дэд бүтцийн нэг юм. Тийм учраас аливаа улсын төлбөр тооцооны дэд бүтэц, үндсэн системүүд тухайн улсынхаа төв банкны хяналтад байдаг, үндэсний аюулгүй байдалд онцгой нөлөөтэй дэд бүтцэд тооцогддог. Манай улсын хувьд Монголбанкны ҮЦГТ нь банк хоорондын төлбөр тооцооны үндсэн сүлжээ, дэд бүтцийг байгуулан хариуцаж байна.

2018 онд бид банк дундын цахим гарын үсгийн баталгаажуулалтын систем, түүний техникийн дэд бүтцийг ҮЦГТ-д бий болголоо. Банк санхүүгийн байгууллага дундын мэдээлэл солилцоо, төлбөр тооцоог цахим гарын үсгээр баталгаажуулж, нууцлал аюулгүй байдлыг өндөр түвшинд хангах боломжтой болж байна гэсэн үг.

МОНГОЛБАНКНААС САНААЧИЛЖ, ОЛОН НИЙТИЙН ХҮРТЭЭЛ БОЛГОСОН, ҮР ДҮНГЭЭ ӨГСӨН, ХҮН БҮР АШИГЛАЖ БАЙГАА ЧУХАЛ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ ҮНДЭСНИЙ ₮ КАРТ ГЭЖ ИРГЭД ҮЗДЭГ. БИД ӨДӨР ТУТМЫН ХЭРЭГЦЭЭНД ₮ КАРТАА АШИГЛАЖ, ОДОО ҮНДСЭНДЭЭ МИНИЙ ХУВЬД ₮ КАРТ ГОЛ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГЛЭЭ БОЛСОН. БУСАД ИРГЭДИЙН ХУВЬД Ч АДИЛ БАЙГАА БОЛОВ УУ.

Үндэсний ₮ карт манай иргэдийн дотоод төлбөр тооцоондоо өдөр тутам, хамгийн өргөн хэрэглэдэг төлбөрийн хэрэгсэл юм. Үндэсний ₮ картыхаа нууцлал, аюулгүй байдлыг

сайжруулах зорилгоор чип технологитой болгох ажлыг хийж байна. Бид энэ ажлаа олон улсын томоохон картан байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, тэдний нэгэнт туршигдсан, баталгаатай болсон технологийн шийдлүүдийг шууд ₮ картдаа авч ашиглахаар яриа, хэлэлцээ өрнөж байна.

Монголбанкнаас үндэсний ₮ карт нь дотоод төлбөр тооцоонд тэргүүлэх төлбөрийн хэрэгсэл байх бодлого барьж, ₮ картан хэрэглээг бүх талаар дэмжих, нууцлал аюулгүй байдлыг сайжруулах, эдийн засгийн хувьд ₮ картыг гаргагч, дэмжигч байгууллагуудад үр өгөөжтэй байлгах талаар бүх талаар дэмжиж ажиллана. ₮ картыг чип технологитой болгох ажил хийж байгаатай холбогдуулан ₮ картыхаа лого, зарим дизайныг өөрчилж шинэчлэх ажлыг үе шаттай хийж байна. Үндэсний ₮ картаа олон улсын төлбөр тооцоонд гаргах, гадаад улс орнуудад хэрэглэх боломжтой болгох чиглэл баримталж байна. ₮ картыг гадаадын улс орнуудад ашигладаг болгох чиглэлээр олон улсын томоохон картан байгууллагууд, бусад улсын төв банкуудтай хэлэлцээр ид хийж эхлэв.

Манай иргэдийн төлбөр тооцоогоор дамжуулан төрөөс хүртдэг үйлчилгээнүүдийн нэг нь төрийн зүгээс хэрэгжүүлж байдаг нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ шүү дээ. Жишээ нь, хүүхдийн мөнгө олгох, эмзэг бүлгийн иргэдэд олгодог татаас ч гэдэг юм уу. Төрийн эдгээр үйлчилгээ авч буй иргэд төлбөрөө хүлээх авахад зарим хүндрэлтэй тал байдаг. Энэ талаар ямар үр дүн

гарах вэ?

Засгийн газраас хэрэгжүүлж буй зарим төрлийн төрийн үйлчилгээний төлбөр тооцоог иргэдэд хүргэхэд Монголбанк ҮЦГТ-өөрөө дамжуулан оролцдог. Эдгээр үйлчилгээг иргэдэд хүргэхэд Монголбанк, Сангийн яам болон төрийн бусад байгууллагатай хамтран шат дараалалтай арга хэмжээ авч, аль болох түргэн шуурхай, чирэгдэлгүй байхаар зохицуулан ажиллаж байна. Монголбанк нь Төрийн үйлчилгээний төлбөр тооцоог цахимжуулах ажлыг эхлүүлж, үүнд нийцүүлэн хууль эрх зүйн орчны зохицуулалтыг бий болгож, өөрийн системд програм хангамжийн хөгжүүлэлтийг хийж, төрийн үйлчилгээний төлбөр тооцоог дамжуулан гүйцэтгэх дэд бүтцийг бий болгоод байна. Одоогийн байдлаар иргэд Нийслэлийн цахим үйлчилгээний Eservice порталаар дамжуулан, мөн Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд байрших ПОС төхөөрөмж ашиглан төрийн үйлчилгээний төлбөрөө шууд төлөх боломжтой. Тодруулбал иргэд банкинд очихгүйгээр, аль ч банкны карт ашиглан давхар зардал, чирэгдэлгүйгээр төрийн үйлчилгээг авах юм.

Мөн Төрийн үйлчилгээ авч буй иргэний төлбөр тооцоо нь Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн системээр дамжин боловсруулагдаж, тухайн агшин бүрт харилцагчийн гүйлгээ баталгаажиг, гүйлгээ нь бодит цагийн горимоор хийгдэж байна. Цаашид Монголбанк нь төрийн үйлчилгээг иргэн бүрд хүртээмжтэй байлгах, үйлчилгээний таатай

орчныг бүрдүүлэхэд Засгийн газар, түүний харъяа агентлагууд, Нийслэлийн төр захиргааны байгууллагууд, банкууд, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч бүхий л байгууллагуудтай хамтран ажиллаж, төрийн төлбөр тооцооны үйлчилгээг хурдан шуурхай, чирэгдэлгүй болгоход хувь нэмэр оруулан ажиллах болно.

БИД МОНГОЛБАНКНЫ ШИНЭЭР НЭВТРҮҮЛЖ БҮЙ ТӨЛБӨР ТООЦОО, ШИНЭ ДЭВШИЛТЭЙ АЖЛУУДЫН ТАЛААР ЯРИЛЦЛАА. ЭНЭ ТОМ ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР АЖИЛ ХИЙГДЭХ ҮҮ?

Монголбанкны болон төлбөр тооцооны салбарын ажилтнуудын мэдлэг чадварыг сайжруулах, сургаж дадлагажуулах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх явдал маш чухал боллоо. Мэдээллийн технологи, төлбөр тооцооны чиглэлийн мэдлэг, туршлагатай мэргэжилтнүүдийн хэрэгцээ их байна.

Үндэсний төлбөрийн системийн хууль нь банк бус компаниуд энэ салбарын оролцогч байх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгогч байх боломж олгосон нь энэ салбарын өрсөлдөөн, хүний нөөцийн чадавхийн хөгжилд эергээр нөлөөлж, дэмжлэг болж байна.

Монголбанкны болон арилжааны банкуудын мэдээллийн технологи, төлбөр тооцооны холбогдох мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах, сургалтад хамруулах ажил үе шаттайгаар хийгдэх болно.

АСН+

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН

ДАВУУ ТАЛ



Системийн ачаалал

Гүйлгээг багцлан богино хугацаанд илгээснээр системийн ачаалал, зардлыг бууруулна. Ингэснээр хүүхдийн мөнгө зэрэг олголтыг 1-5 минутад дамжуулдаг боллоо.



Цаг хугацаа

Дебит гүйлгээг нэвтрүүлснээр харилцагчид байнгын давтамжтай аливаа хуваарьт төлбөр, тухайлбал хэрэглээний, гар утасны төлбөр, зээлийн эргэн төлөлт зэргийг цаг хугацаанд нь төлөх нөхцөл бүрдлээ.

Тооцооллын эрсдэл



Нөөц хөрөнгийг дансанд урьдчилан төвлөрүүлснээр үр дүнгийн тооцооллын эрсдэл үгүй болно.

Түргэн шуурхай



Аж ахуйн нэгж, байгууллагууд тус системд шууд холбогдон, банкаар дамжихгүйгээр байгууллагын төлбөр тооцоогоо шуурхай гүйцэтгэх боломжтой болов.

Дансны нэгдсэн сан



Дансны нэгдсэн санг нэвтрүүлснээр харилцагчид утасны дугаар, цахим хаяг зэрэг нэмэлт мэдээлэл ашиглан гүйлгээ илгээх, хүлээн авах боломжтой боллоо.



Монголбанкнаас банк хоорондын бага дүнтэй гүйлгээнд АСН+ буюу Автомат клиринг хаус системийг нэвтрүүллээ. Бодит цагийн горимын буюу гүйлгээг илгээсэн даруйд хүлээн авагчийн дансанд тусгагдах боломжтой системээ орчин үеийн шаардлагад нийцүүлснээс гадна шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийн гүйлгээг дамжуулах чадавхтай болов.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС... (2019.08.29)

Монголбанкны сар тутмын ээлжит хэвлэлийн бага хурал наймдугаар сарын 29-ний өдөр болж, банк санхүүгийн секторын статистик мэдээллийг хүргэлээ. Мөн Монголбанкны удирдлагууд цаг үеийн асуудлаар сэтгүүлчдийн асуултад хариулав.

25 ТВ:

Инфляци 7.8 хувьтай байна. Энэ оны төгсгөлд зорилтот түвшинд барих боломж байна уу?

МБГ-ын захирал **Б.БАЯРДАВАА:**

Инфляци хамгийн сүүлийн тоон мэдээллээр долоодугаар сарын эцсийн байдлаар улсын хэмжээнд 7.7 хувьтай байгаа. Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг УИХ-аас батлахдаа инфляцийг 2020 оныг хүртэл 8 орчим хувьд тогтворжуулах зорилт батлагдсан. Монголбанкны зүгээс инфляцийг 8 орчим хувьд тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлж байна. Түрүүн дурдсанчлан улсын хэмжээнд инфляци одоогоор 7.7 хувьтай байна. Улаанбаатар хотын инфляци 9 хувьтай гарсан. Инфляцийн хэлбэлзлийг тайлбарлаж байгаа нэг том хүчин зүйл нь махны үнэ юм. Нийт инфляцийн 30 хувь нь дангаараа махны үнийн хэлбэлзэлтэй холбоотой байгаад байна. Мөн дэлхийн зах зээл дээрх нефтийн үнийн хэлбэлзэл дотоодын зах зээл дэх бензиний үнээр дамжуулж инфляцид нөлөө үзүүлж байна. Долоо, наймдугаар сард бензиний үнэ бага зэрэг буурсан нь инфляцийг бууруулах нөлөө үзүүлсэн. Эдгээрээс гадна гэр хорооллын өрхүүдийн түлшинд хэрэглэгдэж байгаа нүүрс, модны үнийн өсөлт инфляцийг их өндрөөр хэлбэлзүүлж байна. Барэг

сүүлийн нэг жил гаруйн хугацаанд. Гэр хорооллын өрхийн хэрэглээнд сайжруулсан түлшийг энэ оноос нэвтрүүлэх гэж байгаа. Сүүлийн үед бидний авч байгаа мэдээллээр энэ нь харьцангуй хямд, элчлэг чанар өндөртэй байна. Энэ утгаараа цаашдаа хатуу түлшний үнээр дамжин орж ирэх инфляцийн нөлөөлөл буурах болов уу гэсэн хүлээлттэй байна. Наймдугаар сарын инфляцийн хүлээлтэд нөлөөлөх бас нэгэн хүчин зүйл нь шинэ ногоотой холбоотойгоор хүнсний ногооны үнийн хэлбэлзэл байна. Өнгөрсөн жил ногооны үнэ нэлээд хэлбэлзсэн бол энэ оны хувьд харьцангуй гайгүй, инфляцийг бууруулах нөлөө үзүүлэх болов уу гэж харж байгаа. Эдгээр нийлүүлэлтийн хүчин зүйлсээс гадна энэ оны хоёрдугаар улирлаас эхлэн нэмэгдсэн цахилгаан, дулаан, ус зэрэг төрийн зохицуулалттай бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт инфляцид нөлөө үзүүлж байна. Мөн наймдугаар сарын инфляцид Их дээд сургуулиудын төлбөр нөлөө үзүүлнэ. Гэх зэрэг нийлүүлэлтийн шинж чанартай инфляцийн хэлбэлзлийг хасаад, эдийн засгийн идэвхжилтэй холбоотой суурь инфляцийг харвал сүүлийн 2 жил орчмын хугацаанд 4-5 орчим хувьд маш тогтвортой байгаа. Энэ утгаар нь харвал 2020 он хүртэл инфляцийг 8 орчим хувьд тогтворжуулах бидний зорилт биелэх боломжтой гэж үзэж байна.

ӨДРИЙН СОНИН:

2021 оноос Монгол Улс бондуудын өр төлж эхэлнэ. Өнөөгийн эдийн засгийн суурин дээр өрийг төлөхөд хэцүү байх. Хэрвээ ЗГ өрөө төлж чадахгүйд хүрвэл төв банкны үйл ажиллагаанд нөлөөлөх үү, жишээлбэл, валютын нөөцийг барьцаалах ч юм уу. Тэгэхээр өр төлөх чиглэлд ямар бэлтгэл ажил хийгдэж байгаа вэ?

МБГ-ын захирал **Б.БАЯРДАВАА:**

2021 оноос төлөгдөх гадаад өрүүдийн тухайд хувийн болон улсын секторын өрийн асуудал яригдаж байгаа. Мэдээж эдийн засгийн нөхцөл байдал харьцангуй сайн байна. Гадаад орчинд тодорхой бус байгаа боловч манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн үнэ харьцангуй гайгүй байх төлөв байна. Хамгийн их уруудаж байгаа нь зэсийн үнэ. Зэсийн үнэ оны эхэнд 6000 орчим ам.доллар байсан бол 5700, 5600 болж буурсан. Үүний нөгөө талд алтны үнэ, төмрийн хүдрийн үнэ өссөн. Нүүрсний үнэ нэлээд уруудах боловч уу гэж харсан ч харьцангуй гайгүй байна. Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал оны эхний хагасын байдлаар 7.3 хувийн өсөлттэй байна. Эдийн засгийн өсөлт харьцангуй сайн байгаа нь гадаад өрийн дахин санхүүжилтэд сайнаар нөлөөлнө. Нөгөө талдаа олон улсын зах зээл дэх жишиг хүүнүүд буурч эхэлсэн. АНУ-ын Засгийн газрын бондууд, Холбооны нөөцийн банкны хүү буурч байгаа зэрэг нь өрийг дахин санхүүжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Монголбанкнаас сүүлийн хугацаанд гадаад өрийн эргэн төлөлт ойртож байгаа, үүнд бэлтгэлтэй байна шүү гэдэг байдлаар асуудалд хандаж байна. Энэ утгаараа Монголбанк эдийн засгийн гадаад орчны таатай нөхцөл байдлын үед эдийн засаг руу орж ирж байгаа валютын урсгалыг, валютын нөөцөө нэмэгдүүлэхэд ихээр ашиглаж байна. Үүний нөгөө талд үүсч байгаа асуудал нь валютын ханш дээр дарамт ирж байгаа. Яагаад гэвэл нөөц хуримтлуулж байгаа, ирээдүйд төлөх ёстой өр, төлбөрүүд байгаа учраас тэр. Тэгэхээр бид аль болох балансыг алдагдуулахгүй түвшинд энэхүү хоёр бодлогын стратегийг хэрэгжүүлээд явж байна.

Ийгл ТВ:

Монголбанкны алт худалдан авалт он гарснаас хойш буурч байна. Үүнд юу нөлөөлж байгаа вэ. Алт худалдан авалтыг нэмэгдүүлэх чиглэлд

Монголбанк хэрхэн ажиллаж байна вэ?

НУСЗГ-ын захирал **А.ЭНХЖИН:**

Монголбанкны алт худалдан авалттай холбоотой мэдээллийг хүргэе. Өнөөдрийн байдлаар Монголбанк дотоодын зах зээлээс 9.5 тонн алт худалдан авсан байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.2 тонноор буурсан. Үүний гол шалтгаан нь 2019 оны нэгдүгээр улиралд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нэмэгдсэн. Үүнээс шалтгаалж Монголбанкны алт худалдан авалт ялангуяа 2019 оны нэгдүгээр улиралд өмнөх онтой харьцуулахад ихээхэн хэмжээгээр буурсан. Энэхүү бууралт ерөнхийдөө хадгалагдсаар өнөөдрийг хүргээд байна. Монголбанк өнгөрсөн онд 22 тонн алт худалдан авсан бөгөөд энэ онд ч мөн дээрх үзүүлэлтэд хүргэх зорилт тавин ажиллаж байгаа. Гэхдээ ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нэмэгдэж, алт тушаалтын хэмжээ буурсантай холбоотойгоор алт худалдан авалт дээрх дүнд хүрэхгүй байх эрсдэл өндөр байна. Монголбанкнаас алт тушаалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Эх орныхоо алтыг эрдэнэсийн сандаа” аяныг 10 дугаар сарыг дуустал хэрэгжүүлж ажиллаж байна. Энэ хүрээнд алт худалдан авалтыг сурталчлах, алт худалдан авалтын эдийн засагт үзүүлэх үр нөлөөг тайлбарлан таниулах ажлыг хийж байгаа.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ:

Ипотекийн санхүүжилтийн талаар сүүлийн үеийн мэдээллийг өгнө үү. Засгийн газар, Монголбанк, арилжааны банк хамтран ипотекийн санхүүжилтийг олгож эхэлсэн. Ингэснээр тодорхой ямар үр дүн гарч байна вэ?

НУСЗГ-ын захирал **А.ЭНХЖИН:**

Ипотекийн хөтөлбөрийн хувьд эхний найман сарын байдлаар Монголбанк, Засгийн газар, арилжааны банк хамтраад 283 тэрбум төгрөгийг нийт 4000 орчим зээлдэгчдэд олгоод байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 100 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт болж байна. Монголбанкнаас энэ онд хэрэгжүүлж байгаа шинэчилсэн бүтцээр энэ оны нийт санхүүжилт 430 орчим тэрбум төгрөгт хүрэх тооцоо бий. Ингэснээр нийт санхүүжилтийн хэмжээ 1.5 дахин, зээлдэгчийн тоо 2 дахин өсөх хүлээлт бий. Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанкийг ипотекийн хөтөлбөрөөс 2020 оны нэгдүгээр сарын 1-нээс гарах шаардлагыг тавьсан. Энэ шаардлагыг 2017 оноос хойш

тавьж байсан ч Монголбанкны зүгээс хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлэх хувь нэмрийг харгалзан үзэж, хөтөлбөрөөс гарах хугацааг 2020 оны нэгдүгээр сарын 1 хүртэл хойшлуулсан. Энэ дагуу Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан тушаалаар Монголбанк хөтөлбөрөөс гарах төлөвлөгөө батлагдсан. Энэ дагуу холбогдох бэлтгэл ажлууд хийгдээд явж байна.

ТВ8:

Банк бус санхүүгийн байгууллагуудын хүүгийн асуудлаар санхүүгийн зохицуулах хороо хяналт тавьж байгаа. Гэхдээ Монголбанк үүн дээр ямар нэгэн бодлого баримталж, СЗХ-той хамтардаг уу. 7 хоногийн 10 хувь, сарын 30 хувийн хүүтэй зээл хүртэл олгож байна шүү дээ. Эрх зүйн зохицуулалт хийх боломж байгаа юу?

МБГ-ын захирал Б.БАЯРДАВАА:

Бид СЗХ, Монголбанкны хамтарсан уулзалтыг зохион байгуулсан. Энэ үеэр банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн хүү, зээлийн өсөлт, дарамт, Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа хэрэглээний зээлийг хязгаарлах бодлогын арга хэмжээг банк бус, санхүүгийн байгууллагуудад хэрэгжүүлэх бололцоо байна уу гэх зэрэг асуудлыг ярилцсан. Бидний ойлгосноор Санхүүгийн зохицуулах хороо эдгээр асуудлыг зарчмын хувьд дэмжиж байгаа юм билээ. Монголбанкны хувьд эрх зүйн статусаараа банк бус санхүүгийн байгууллагуудад бодлогын зохицуулалт хийх, хяналт, шалгалт хийх боломжгүй. Тийм учраас энэ чиглэлд Санхүүгийн зохицуулах хороотой аль болох хамтран ажиллахыг хичээдэг.

ЗГМ:

Арилжааны банкуудын өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн эх үүсвэрт аудит хийгээд, үр дүнг зарлах хугацааг хойшлуулсан. Ямар шалтгаантай вэ, хэзээ үр дүнг зарлах вэ?

ХШГ-ын захирал Н.БАТСАЙХАН:

Банкуудын өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн эх үүсвэрт аудит хийх ажлын үр дүнг зарлах хугацаа хойшлогдсон гэдгийг бид өмнө нь мэдээлсэн. Гол шалтгаан нь анх хүлээгдэж байснаас илүү их материалыг хүлээж авах, түүнийг шалгаж, нягтлах шаардлагатай болсон. Мөн нэмэлт нотлох баримтуудыг төрийн бусад байгууллага

болон холбогдох газруудаас гаргуулж авах ажлууд нэмэгдсэн. Энэ бүх материалуудыг цуглуулсны дараа англи хэл рүү хөрвүүлэх зэрэг ажлууд бий. Тийм учраас техникийн шинжтэй ажлуудтай холбоотойгоор үр дүнг зарлах хугацаа хойшлогдсон. Гэхдээ бид ойрын хугацаанд тайлангийн үр дүнг зарлах болно.

ТВ9:

Хэрэглээний зээлийг хязгаарлах бодлого хэрэгжиж эхлээд багагүй хугацаа өнгөрлөө. Эдийн засагт ямар өөрчлөлт гарч байна вэ?

МБГ-ын захирал Б.БАЯРДАВАА:

Хэрэглээний зээлийг хязгаарлах бодлогын үр дүнг хэд хэдэн зүйлээр харж болно. 2018 оны байдлаар хэрэглээний зээлийн хүү, өр орлогын харьцаа, хугацаа зэрэг мэдээллүүд маш хомс байсан. 2018 оны 5 дугаар сард бид түүвэр судалгаа хийж үзэхэд хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа дунджаар 69 хувьтай байсан. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр иргэд сарын орлогынхоо 69 хувийг хэрэглээний зээлд зарцуулж байна гэсэн үг. 2019 оны зургаадугаар сарын байдлаар энэ үзүүлэлт 58.9 хувь болж буурлаа. Хоёрдугаарт, банкны системээс олгож байгаа нийт хэрэглээний зээлийн түвшин өнгөрсөн оны эцсээс бараг 200 тэрбумаар буурсан байна. Гуравдугаарт, хэрэглээний зээлийг хязгаарласнаар бизнесийн зээл өсөхөд түлхэц болно гэж бид хүлээж байсан. Үүний үр дүнд 2018 оны сүүлийн хагасаас бизнесийн зээлийн өсөлт сэргэж, өнөөдрийн байдлаар өсөлт нь харьцангуй тогтвортой байна. Үүнээс гадна банкууд жижиг, дунд бизнесийн зах зээл дээр нэлээд өрсөлдөж байгаа. Энэ утгаараа жижиг, дунд бизнесийн зээлийн өсөлт нэмэгдэж байна. Ялангуяа, иргэдийн жижиг, дунд бизнесийн зээлийн өсөлт өндөр, тэр дотроо зээлийн чанаргүйдэлт харьцангуй бага түвшинд байгаа гэх зэргээр бодлогын арга хэмжээний үр дүн харагдаж байна. Үүний нөгөө талд хүмүүс банк бус санхүүгийн байгууллагууд руу очиж, тэндээс өндөр хүүтэй зээл авах хандлага ажиглагдаж байгаа. Энэ асуудал цаашид гүнзгийрэх вий гэх болгоомжлол бий.

ТВ5 телевиз:

"Саарал жагсаалт"-тай холбоотой асуудлаар саяхан олон улсын байгууллагын хуралд оролцож, тайлангаа хамгаалаад ирсэн. Энэ хурлаар ямар үр дүн гарсан бэ?

ХЭЗГ-ын захирал **Д.АЮУШ:**

Ази, Номхон далайн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бүлгийн хуралд Монголын баг оролцож, тайлангаа хамгаалаад ирсэн. Гэхдээ Ази, Номхон далайн бүлгийн дүрмийн дагуу албан ёсны дүгнэлт гарах хүртэлх хугацаанд ямар нэгэн мэдээлэл өгөх боломжгүй. Албан ёсны дүгнэлт гараагүй учраас юм. Харин дүгнэлт гарсан даруйд бид мэдээллийг албан ёсны сувгаараа дамжуулан өгнө. Энэ удаад бид эхний ээлжийн тайлангийн хамгаалалтаа хийсэн. Есдүгээр сард үр дүнгийн үзүүлэлтийн тайлангийн хамгаалалтад явахаар бэлтгэл ажлаа хийж байна.

ИЙГЛ ТВ:


Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өссөн нь юунаас шалтгаалсан бэ? Үүнд ипотекийн зээл хэр их хувийг эзэлж байгаа вэ?

ССГ-ын захирал **Б.БАТДАВАА:**

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 10.6 хувьтай тэнцэж байна. Энэ нь өмнөх сартай харьцуулахад өөрчлөлт ороогүй үр дүн юм. Харин хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 0.7 хувиар нэмэгдсэн. Үүнд голлон нөлөөлсөн хүчин зүйл нь хувийн байгууллагуудын зээлийн хугацаа хэтрэлт нөлөөлсөн. Ипотекийн зээлийн хувьд нийт зээлийн багцийн 95.2 хувь нь хэвийн, 2.3 хувь нь хугацаа хэтэрсэн, 2 хувь нь чанаргүй гэх ангилалтай байна.

1. Мөнгөний үзүүлэлтүүд

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц




- М2 мөнгөний жилийн өсөлт 17.9%-д хүрч 20.3 их наяд ₮-т хүрэв.
- Өмнөх сараас 0.3%-иар буюу 60.4 тэрбум ₮-өөр буурав.

Үүнээс М1 мөнгө 7.6% (321.1 тэрбум ₮) —иар буурч, бусад хадгаламж 2.4% (381.6 тэрбум ₮) —иар өссөн байна.

- М1 → ₮-ийн харилцах 311.9 тэрбум ₮-өөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 9.2 тэрбум ₮-өөр буурав.
- Бусад хадгаламж → \$-ийн хадгаламж 6.8 тэрбум ₮-өөр, ₮-ийн хадгаламж 40.8 тэрбум ₮-өөр тус тус буурч, \$-ийн харилцах 429.2 тэрбум ₮-өөр нэмэгдсэн байна.

Зураг 1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум




1. Мөнгөний үзүүлэлтүүд

Зураг 1.3. Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц




Зураг 1.4. Нийт хадгаламж




- Нийт М2 мөнгөний нийлүүлэлтийн 53.7%-ийг ₮-ийн хадгаламж бүрдүүлж байгаа бол 15.5%-ийг ₮-ийн харилцах, 14.4%-ийг \$-ын хадгаламж, 13.2%-ийг \$-ын харилцах, үлдсэн 3.2%-ийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлж байна.
- Нийт хадгаламжийн хэмжээ 13.8 их наяд ₮-т хүрснээс 84.1%-ийг иргэдийн хадгаламж, 15.9%-ийг байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.
- Иргэдийн хадгаламжийн 20.7%-ийг, байгууллагын хадгаламжийн 21.7%-ийг гадаад валютын хадгаламж бүрдүүлж байна.

2. Зээл, түүний өсөлт

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор



Зураг 2.2. Нийт зээл, гадаад валютын эзлэх хувь



- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс **17%-иар** өсч **18.1** их наяд төгрөг,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл **22%-иар** өсч **9.3** их наяд төгрөг,
- Хувийн байгууллагынх **12%-иар** өсч **8.7** их наяд төгрөгт тус тус хүрчээ.
- Нийт зээлийн **13%-ийг**, Иргэдийн зээлийн **1.6%-ийг**, Хувийн байгууллагын зээлийн **26%-ийг** гадаад валютын зээл бүрдүүлж байна.

2. Зээлийн бүтэц

Зураг 2.3. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар



Зураг 2.4. Зээл, зээлийн чанар



- Нийт зээл **18.1 их наяд** (Төгрөгийн зээл **15.7** их наяд ₮, Валютын зээл **2.4** их наяд ₮)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **61 тэрбум** буюу **0.3%-иар** өссөн.
- Хэвийн зээл өмнөх сараас **84 тэрбум** буюу **0.5%-иар** буурсан.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас **126 тэрбум** буюу **16.9%-иар** өссөн.
- Чанаргүй зээл өмнөх сараас **18.7 тэрбум** буюу **1%-иар** өссөн байна.


3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Тайлант сард олгосон ипотекийн зээл



Тайлант сард банкууд **741** зээлдэгчид **57.1** тэрбум ₮-ийн ипотекийн зээл шинээр олгосноос **45.5%** нь хөтөлбөрийн, **54.5%** нь банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл байв.


Зураг 3.2. Тухайн сард олгосон ипотекийн зээлийн хүү




Шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх оны мөн үеэс **0.6** нэгж хувиар буурчээ.

4. Шинээр татсан хадгаламж, шинээр олгосон зээл

Зураг 4.1. Нийт шинээр татсан хадгаламж, хүү




Зураг 4.2. Нийт шинээр олгосон зээл, хүү




- Иргэдээс татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ **11.2%**, хувийн байгууллагаас татсан төгрөгийн хадгаламжийн ЖДХ **9.0%** байна.
- Иргэдэд шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ **17.4%**, хувийн байгууллагад олгосон төгрөгийн зээлийн ЖДХ **17.1%** байна.

4. Зээл, хадгаламжийн хүү

Зураг 4.3. Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү




Зураг 4.4. Нийт зээлийн үлдэгдэл, хүү



- Иргэдийн төгрөгийн хадгаламжийн ЖДХ **11.5%**, хувийн байгууллагын төгрөгийн хадгаламжийн ЖДХ **11.5%** тай байна.
- Иргэдийн төгрөгийн зээлийн ЖДХ **17.9%**, хувийн байгууллагын төгрөгийн зээлийн ЖДХ **15.7%**-тай байна.

5. Төлбөрийн тэнцлийн статистик, 2019 оны эхний 6 сар



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ГУЛУУЗ МӨНГӨ

Бохир жин: 38.080 гр
Цэвэр жин: 38.0038781 гр
Сорьц: 999
Хэмжээ: 29.5 x 12.5 x 9.5 см

Тэгш өнцөгт гонзгой хэлбэртэй.

Гулууз мөнгөн дээр "1091224.20 oz. Fine 999, S.S.L.CO, SAN FRANCISCO гэж англиар цохисон.





АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСАД ХАРААТ БУС ТӨВ БАНК ХЭРЭГТЭЙ

Төв банкны хараат бус байдал сэдвээр Америкийн төв банк- Холбооны нөөцийн сангийн тэргүүн асан П.Волкер (1979-1987), А. Грийнспан (1987-2006), Б.Бернанке (2006-2014), Ж.Йеллен (2014-2018) нарын байр суурийг орчуулан хүргэж байна.

Төв банк улс төрийн дарамтаас ангид үед эдийн засгийн төлөв сайн байдаг.

Төв банк болон түүний тэргүүн эдийн засгийн байдлын төлөө хараат бусаар ажлаа хийн улс төрийн дарамтаас ангид байх, ялангуяа улс төрийн зорилгоор

Төв банкны тэргүүнийг огцруулах заналхийллээс ангид байх ёстойг тайлбарлахын тулд Холбооны нөөцийн системийн захирлуудын зөвлөлийг удирдаж байсан бид ийнхүү нэгдээд байна.

Бид дөрөв нийлээд 40 орчим жил улсдаа хүчин зүтгэсэн бөгөөд,

Ардчилсан нам болон Бүгд найрамдах намын аль алинаас гаралтай Америкийн Нэгдсэн Улсын 6 Ерөнхийлөгч (Ж.Картер, Р.Рейган, Ж.В.Буш, Б.Клинтон, Ж.Буш, Б.Обама) биднийг томилж, зарим тохиолдолд бүрэн эрхийн хугацааг сунгаж байв. Бидний хэн хэн нь хуулиар заасан Холбооны

нөөцийн сангийн зорилго болох “бүрэн ажил эрхлэлт” болон “үнийн тогтвортой байдал”-ыг хангахын тулд хүнд шийдвэрүүдийг гаргаж байсан. Эргээд харахад, бидний шийдвэр болгон төгс байгаагүй. Гэхдээ шийдвэрүүд түр зуурын улс төрийн ашиг сонирхол бус, харин америк иргэдийн эдийн засгийн урт хугацааны тусын тулд нам бус, улс төрийн бус үнэлэмжид тулгуурлаж гарч байснаараа сайн байж чадсан гэдэгт бид итгэдэг.

Холбооны нөөцийн сангийн нам бус статус нь огт хяналтгүй, эгэх хариуцлагагүй (accountability) гэсэн үг биш. Конгрессээс төв банкны эрх мэдлийг тодорхойлж өгдөг бөгөөд бүрэн ажил эрхлэлтийг хангах, үнийн тогтвортой байдлыг хадгалахыг даалгадаг. Төв банкны тэргүүн болон Холбооны нөөцийн системийн бусад удирдлагууд Конгрессийн өмнө нээлттэй сонсгол хийхийн зэрэгцээ олон нийтэд хандсан яриа илтгэлээр дамжуулж эдийн засгийн байдлын талаарх үнэлэлт дүгнэлтээ, хуулиар ногдсон үндсэн үүргээ хэрхэн биелүүлэх төлөвлөгөөгөө тогтмол тайлбарладаг. Америкийн Ерөнхийлөгч, Конгрессийн гишүүд, санхүүгийн зах зээлийн оролцогчид, эрдэмтэд болон хувийн хэвшил жирийн иргэд ч Төв банкиг тодорхой ямар нэг бодлогын шийдвэр гаргахад зөвлөж байдаг. Энэ нь манай улсын засаглалын тогтолцоонд хүн бүрт байх ёстой эрх тул бид үүний эсрэг байдаггүй. Холбооны нөөцийн сан нээлттэй хэлэлцүүлгийг дуртай хүлээж авдгийг харуулах нэг жишээ бол “Fed listens” буюу “Төв банк сонсож байна” хөтөлбөр бөгөөд үүний

хүрээнд Төв банкны удирдлагууд олон нийттэй харилцаж, бодлогын арга хэлбэрт орж магадгүй зарим өөрчлөлтийн талаар тайлбарладаг. Олон нийтийн идэвхтэй хэлэлцүүлэг мөнгөний бодлогыг илүү сайн болгоход ч тусалдаг.

Төв банк улс төрийн дарамтаас ангид, зөвхөн эдийн засгийн хатуу зарчим болон тоон мэдээлэлд үндэслэн үйл ажиллагаагаа явуулах үед эдийн засаг хүчтэй байж, хамгийн сайнаараа ажилладаг болохыг манай орны ч, гадаад улс орны ч тэртүүх ахин дахин харуулсан билээ. Сонгуулийн үеэр улс төрийн лидерүүд төв банкнаас эдийн засгийг богино хугацаанд дэмжих мөнгөний бодлого явуулахыг шаардсан жишээ маш олон бий. Харин судалгаа мөнгөний бодлого улс төрийн хүсэл шаардлагад тулгуурлахаар алс хэтдээ эдийн засгийн муу гүйцэтгэлийг бий болгож, өндөр инфляци болон эдийн засгийн тааруу өсөлтөд хүргэдэг. Тэр ч бүү хэл мөнгөний бодлогын шийдвэрүүд “улс төрийн ашиг сонирхлын нөлөөнд байна”, эсвэл “бодлого боловсруулагчдыг хугацаанаас нь өмнө огцруулна гэдэг заналхийллийн нөлөөнд байна” хэмээн ойлгогдох нь “төв банк эдийн засагт хамгийн тустай зүйлийг хийнэ” гэсэн олон нийтийн итгэлийг бууруулдаг. Энэ нь санхүүгийн зах зээл дээрх тогтворгүй байдал, эдийн засгийн таагүй үр дүнд хүргэх эрсдэлтэй.


Нам бус, хараат бус мөнгөний бодлого маш чухал байдаг учраас Конгресс ухаалгаар шийдэж Холбооны нөөцийн санг хараат бус агент болгосон бөгөөд бүс нутгуудын төлөөллийг хангаж, улс

төрийн манипуляциас хамгаалж өгсөн. Тэдгээр хамгаалалтын нэг нь Холбооны нөөцийн сан (ХНС)-ийн захирлуудын зөвлөлийн гишүүдийн 14 жилийн бүрэн эрхийн хугацаа (тэргүүн болон дэд тэргүүн нар 4 жил) юм. Мөн Холбооны нөөцийн системийн салбар банкны захирлууд болон ХНС-ийн тэргүүн, дэд тэргүүнийг улс төрийн лидерүүдтэй бодлогын талаарх зөрүүтэй байр сууринаас болж бус, зөвхөн хууль зөрчсөн эсвэл төстэй зүй бус үйлдэл гаргасан тохиолдолд л ажлаас нь чөлөөлөх боломжтой явдал юм. Бүрэн эрхийн хугацааг ийнхүү хатуу тогтоосон нь төв банкны шийдвэр улс төрийн нөлөөллөөс ангид байж, эдийн засаг болон Та бидний тусын тулд байлгахын тулд билээ.

Сонгууль бүр үр дагавартай байдаг. Энэ нь Холбооны нөөцийн сан болон Засгийн газрын бусад агентуудад ч хамаарна. Одоогийн төв банкны тэргүүний 4 жилийн бүрэн эрхийн хугацаа дуусахад Америкийн Ерөнхийлөгч түүнийг дахин томилох, эсвэл шинэ хүнийг нэр дэвшүүлэх боломжтой. Нэр дэвшүүлсэн хүнийг Сенат батлах ёстой. Тэрхүү шийдвэрийг гаргах үед нэр дэвшигчийг улс төрийн холбоо сүлбээ, үйл ажиллагаа бус, харин ур чадвар, үнэнч шударга байдлыг нь харж сонгоосой гэж бид найдаж байна. Холбооны нөөцийн сан хэсэг бүлэг улстөрчдийн төлөө бус, харин энэ улсын эрх ашгийн төлөө шийдвэр гаргах чадвартай байдлыг хамгаалах нь онцгой чухал юм.

Эх сурвалж: Wall Street Journal


ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ҮНДСЭН



ТӨВ БАНКНЫ ХАРААТ БУС БАЙДЛЫГ ҮНДСЭН ХУУЛИНДАА ТУСГАСАН УЛС ОРНУУД:

- Аргентин
- Бразил
- Болгар
- Чили
- Хорват
- Чех
- Финланд
- ХБНГУ
- Унгар
- Индонез
- Малайз
- Мексик
- Филиппин
- Польш
- Португали
- ОХУ
- Сингапур
- Словак
- Өмнөд африк
- Швейцари
- Швед гэх мэт нийт 35 улс нь Төв банкны хараат бус байдлыг Үндсэн хуулиндаа тусгасан байдаг бол 65 улс бусад хуулиндаа багтаасан байдаг.

ХУУЛИНДАА ТУСГАСАН УЛС ОРНУУД



- Төв банкны хараат бус байдлыг Үндсэн хуулиндаа тусгасан улс орнууд
- Төв банкны хараат бус байдлыг Үндсэн хуулиндаа тусгаагүй улс орнууд

Эх сурвалж: https://www.bis.org/publ/othp04_3.pdf

МОНГОЛБАНК ОН ГАРСНААС ХОЙШ 9.6 ТОНН АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2019 оны эхний 8 сард 9.6 тн үнэт металл худалдан авсан нь өмнөх оны мөн үед 12.2 тн үнэт металл худалдан авснаас 2.5 тонноор бага буюу 21%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Монголбанк 2019 оны 8 дугаар сард 2.1 тн үнэт металл худалдсан авсан ба үүнээс Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 181.3 кг үнэт металл, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 53.7 кг үнэт металлыг худалдаж авсан нь өмнөх оны мөн үед 2.8 тн үнэт металл худалдан авч байснаас 745.7 кг-аар буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 8 дугаар сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 128,129.80 төгрөг байлаа.



График 1. 2018-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны сарын мэдээ (кг)



График 2. 1990-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (тонн)



График 3. 2019 оны 8 дугаар сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг)

ВАЛЮТ АРИЛЖААНЫ ЦАХИМ ТАЛБАРЫН АРИЛЖААНЫ ТОЙМ

БХВАЦТ-ыг 2017/4/10-нд нэвтрүүлснээс хойш 2019/08/29-ний хооронд 1,443.2 сая ам.долларын болон 113.4 сая юанийн нийт 1219 удаагийн арилжаа БХВАЦТ-т хийгдээд байна.



ИПОТЕКИЙН ЗЭЭЛД 282 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН САНХҮҮЖИЛТ ОЛГОВ

Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2019 оны эхний 8 сарын байдлаар нийт 282 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 3,963 иргэнд олгоод байна. Үүнээс Монголбанкны эх үүсвэрээс 127 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,739 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 75 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,188 иргэнд, банкуудын өөрийн эх үүсвэрээс 80 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 1,036 иргэнд тус тус олголоо.



М.НУРГУЛ: ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД ХУВЬ ХҮНИЙ САНХҮҮГИЙН САХИЛГА БАТ ЧУХАЛ ҮҮРЭГТЭЙ

Монголбанк 2016 оноос Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, олон улсын хэмжээнд үнэлэгдсэн өндөр амжилтыг үзүүлж байгаа билээ. Энэ удаад бид тус хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг тодруулахаар Монголбанкны ОНБМТ-ийн ахлах мэргэжилтэн М.Нургултай ярилцлаа.

МОНГОЛБАНК ЯАГААД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА ВЭ, ҮНДСЭН ҮҮРГЭЭС НЬ ХОЛ МЭТ САНАГДДАГ БАЙЛАА. ЭНДЭЭС ЯРИЛЦЛАГАА ЭХЭЛЬЕ.

Анх энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх хүмүүст эхэндээ тан шиг бодол төрдөг байсан. Аргаггүй юм. Боловсролын байгууллага биш учраас санхүүгийн мэдлэг олгоно гээд зорихоор чинь гайхах, эсвэл үндсэн ажил нь биш байтал... гэж шүүмжлэх хүн ч цөөнгүй таардаг байсан. Гэхдээ Төв банк эдийн засгийг тогтвортой байлгах гол зорилгоо амжилттай биелүүлэхийн тулд санхүүгийн боловсролд анхаарахаас өөр аргагүй байдаг. Учир нь хүн бүр л мөнгө, санхүүтэй холбоотой шийдвэрийг өдөр тутам гаргаж, эдгээр шийдвэрүүдийн үр дүнд эдийн засаг маань бүрэлдэн тогтож байна. Тэгэхээр иргэдийн санхүүгийн мэдлэг сайжирснаар илүү оновчтой үр дүнтэй шийдвэр гаргах боломж нь нэмэгдэж, үүний үр дүнд буюу иргэдийн үрэлгэн бус байдлаас эдийн засаг маань тогтвортой байхад нөлөөлнө гэсэн үг. Түүнчлэн, Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогыг илүү сайн ойлгох нь эргээд мөнгөний бодлогын хэрэгжилт, үр дүнтэй байдалд эергээр нөлөөлдөг. Иймд Төв банкууд санхүүгийн

боловсролд анхаарч буй нь ийм л ач ходбогдолтой бөгөөд мөнгөний бодлогын хэрэгжилтийнхээ үр нөлөөллийг дээшлүүлэхийн тулд хэрэгжүүлж буй чухал бодлогуудыг нь нэг юм. Тийм ч учраас дэлхийд тэргүүлэх төв банкууд бүгд санхүүгийн боловсролын хөтөлбөртэй байдаг. Монголбанк ч бас энэ жишгээр олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарал хандуулж байна.

ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН МЭДЛЭГ, БОЛОВСРОЛ ДЭЭШИЛСНЭЭР ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ, САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛД ҮЗҮҮЛЭХ ХУВЬ НЭМРИЙН ТАЛААР АРАЙ ИЛҮҮ ТОДОРХОЙ ТАЙЛБАРЛАХ НЬ ЗҮЙТЭЙ БОЛОВ УУ ГЭЖ БОДОЖ БАЙНА.

Иргэдийн санхүүгийн мэдлэг сайжирснаар хамгийн түрүүнд иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зөв удирдаж сурна. Өөрөөр хэлбэл, мөнгөө зөв удирдаж чадах мэдлэг, чадвар эзэмшсэнээр хэрэглээгээ зөв тодорхойлж, дадал болгосноор санхүүгийн хувьд сахилга баттай болсноор мөнгөнөөс хараат бус, ирээдүйдээ итгэлтэй амьдарна шүү дээ.

Олон улсад 2000 оноос хойш эдийн засгийн бодлого

тодорхойлогчид санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх асуудал ач холбогдол өндөртэй гэж үзэж, бодлогын хэмжээний баримт бичигт санхүүгийн боловсролын асуудлыг тусгах болсон. Иргэдийн санхүүгийн мэдлэг дээшилснээр тэдний санхүүгийн сахилга бат сайжирч, санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадвар дээшилж, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэл дээшилж, цаашлаад Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлдэг. Ийм л нийгмийн чухал ач холбогдолтой юм.

ТЭГВЭЛ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСНЭЭС ХОЙШ ЯМАР ҮР ДҮНД ХҮРЧ БАЙГАА ТУХАЙ ЯРИЛЦАХГҮЙ ӨНГӨРЧ БОЛОХГҮЙ. ТА ЭНЭ ТУХАЙ МАНАЙ УНШИГЧДАД ДУРЬДАНА УУ?

Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран Дэлхийн банкны техник туслалцааны дэмжлэгээр “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг

дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр"-ийг боловсруулан 2016 оноос үндэсний хэмжээний хөтөлбөр болгон хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийг сургуулийн насныхан болон залуу үеийнхэн, хөдөө орон нутгийн иргэдэд, санхүүгийн мэдлэг олгох сургалтыг биечлэн болон цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан олгох сургалтыг дөрвөн чиглэлийн дагуу хэрэгжүүлдэг. Олон улсын туршлагаас үзэхэд хүний хандлага, дадал өөрчлөгдөхөд дунджаар 5 жилийн хугацаа шаардагддаг. Иймээс бид Санхүүгийн боловсролын хөтөлбөрийг дунд хугацаагаар буюу 6 жилээр баталсан. Үр дүн нь бодитой харагдаж эхэлсэн. Тухайлбал, ЕБС-ийн бүрэн дунд боловсролын сургалтын "Цөм" хөтөлбөрт санхүүгийн боловсрол олгох "Бизнес судлал" нэртэй хичээлийг Х, XI, XII ангид сонгон судлахаар шинээр сургалтын хөтөлбөрт тусгуулсан. Их дээд сургуулиудад мэргэжил харгалзахгүйгээр үзэх "Хувь хүний санхүү" 3 кредит хичээлийг боловсруулж сурах бичиг, дасгал ажлын номыг бэлэн болгож, 10 их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулсан. Дагаад хичээлийг заах багш нар бүрэн бэлтгэгдчихсэн. Орон нутгийн иргэдэд зориулсан сургалт хийдэг гэж дээр хэлсэн шүү дээ. Тэдэнд зориулсан санхүүгийн мэдлэг олгох маш энгийн хялбар хэллэгтэй гарын авлагуудыг боловсруулсан. Тодруулбал, мөнгөө хэрхэн удирдах, төсөв болон санхүүгийн төлөвлөлт, хадгаламж, зээл, хөрөнгө оруулалт, даатгал, тэтгэвэр, нийгмийн даатгал болон татварын талаарх болон санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаарх ойлголт тэрчлэн валютын

ханш хэрхэн тогтдог гэх зэрэг яг л иргэдийн амьдралд хэрэгтэй мэдлэг, мэдээллүүдийг өгсөн санхүүгээ зөв удирдахад нь хөтөч болох агуулгаар нь боловсруулсан. Мөн энэхүү агуулгыг түгээх сургагч багш нарыг БСШУС-ын яамны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран бэлдэж, одоогоор 689 багш багшлах эрхтэй боллоо. Мөн Хөдөлмөрийн яамнаас баталсан Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн "Бизнес, аж ахуй эрхлэх чиг баримжаа олгох" хичээлийн агуулгад "Санхүүгийн суурь мэдлэг, хувь хүний санхүү" сэдэвт хичээлийг заах хот, орон нутгийн 94 багш бэлтгэгдлээ. За, тэгээд мэдээж сошиал ертөнцөд оролцогчдийн тоо эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан www.sankhuuginbolovsrol.mn нэгдсэн цахим хуудас, ухаалаг утас ашигладаг хүн болгонд "Төсөвчин" аппликейшнийг боловсруулж олон нийтэд хүргэлээ. Гол нь санхүүгийн боловсролыг системтэйгээр нэвтрүүлэх нь хамгийн чухал гэж үздэг. Бид хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээгээр 2016-2018 оны хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг үнэлж, өндөрөөр үнэлсэн.

**ЕР НЬ ЭНЭ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯВЦАД
МОНГОЛЧУУДЫН
САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ
ЯМАР ТҮВШИНД ҮНЭЛЭГДЭЖ
БАЙНА ВЭ?**

Дэлхийн банкнаас 2012 онд Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж буй байдал, иргэд олон нийтийн эдийн засаг, санхүүгийн боловсролыг олон улсын түвшинтэй харьцуулан судалгаа хийхэд харамсалтай

нь хангалтгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Судалгаагаар манай улстай ижил түвшний орлоготой бусад орны иргэдийн адилаар Монголчуудын дийлэнх олонх нь хуримтлал болон хөрөнгө оруулалтын хамгийн үр өгөөжтэй шийдвэр гаргах, хууль ёсны эрхээ хамгаалуулахад шаардлагатай санхүүгийн үндсэн ойлголтын талаар дутмаг мэдлэгтэй байгаа нь тодорхой харагдсан. Тиймээс иргэд, үйлчлүүлэгчдийн санхүүгийн шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэг, мэдээллийг хүргэдэг, эрх нь зохих хэмжээнд хамгаалагдсан байхыг баталгаажуулах нь чухал гэж үзсэн.

**ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨРИЙГ АМЖИЛТТАЙ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЮУ ЧУХАЛ
ВЭ?**

Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгыг амжилттай биелүүлэхийн тулд мэдлэгийг системтэй түгээх нь хамгийн чухал гэж би дээр хэлсэн шүү дээ. Тиймээс үүнд төрийн бодлого гол үүрэг гүйцэтгэдэг нь бусад улс орны сайн туршлагаудаас харагддаг. Иймд бодлого тууштай хэрэгжих нь туйлын чухал байдаг. Үүнээс гадна бодлого тодорхойлогчид, боловсролын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хувийн секторын хамтын ажиллагаа ч мөн өндөр үүрэг оролцоотой байх хэрэгтэй байдаг. Харин иргэд өөрсдөө хэр хичээхээс маш их зүйл шалтгаална. Иймд тал бүрээсээ хамтдаа зүтгэж, иргэн бүр нь санхүүгийн боловсролтой, эдийн засаг нь тогтвортой өсөлттэй, өндөр хөгжилтэй улс орон болох нь бүх нийтийн хичээл зүтгэл шүү дээ.

Ярилцсанд баярлалаа.

**ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ
(АМ.ДОЛЛАРААР, 29/VIII ӨДРИЙН БАЙДЛААР)**



Хүснэгт 1. Алтны үнэ, үнийн өсөлт /2019/

	Алтны үнэ	Үнийн өсөлт /QoQ/	Үнийн өсөлт /YoY/
2018Q4	1282	7.6%	-1.5%
2019Q1	1292	0.8%	-2.5%
2019Q2	1409	9.1%	12.5%
2019.07.31	1413	10.1%	15.4%
2019.08.29	1527	16.9%	27.1%

Алсны үнэ сүүлийн 2 сарын хугацаанд огцом өсөхөд голлон нөлөөлсөн хүчин зүйлс болон онцлох үйл явдлыг дараах дүрслэлд харуулан, дэлгэрэнгүй байдлаар тайлбарлав.

Дүрслэл 1. Алтны үнэ, нөлөөлсөн хүчин зүйлс (ам.доллар/унци)



- 2019/06/11 - АНУ Мексик Улсаас импортолдог бараа, бүтээгдэхүүнд 5%-ийн тариф ноогдуулах шийдвэр 6-р сарын 10-наас хэрэгжиж эхлэхээр хүлээгдэж байсан ч АНУ-ын Ерөнхийлөгч тарифын арга хэмжээг цуцалснаа мэдээлж, зах зээлд эерэг хүлээлт үүссэнээр алтны эрэлт тодорхой хэмжээгээр буурсан.
- 2019/06/20 - АНУ-ын ХНБ-ны Холбооны нээлттэй

захын зөвлөлийн 6-р сарын 18-19-нд болсон ээлжит хурлаар бодлогын хүүг 2.5%-д хэвээр үлдээх шийдвэр гаргасан. Мөн уг хурлаар нэгэн тодорхой дохиог өгсөн нь ХНБ бодлогын хүүгээ хамгийн багадаа 25 суурь нэгжээр бууруулахад нээлттэй буйг илэрхийлсэн юм. Үүний зэрэгцээ тус улсын инфляци 5-р сард жилийн дүнгээр 1.8%-тай гарч зорилтот түвшин 2%-д хүрээгүй, шинэ ажлын байрны тоо

төсөөллөөс доогуур байгаа зэрэг нь эдийн засгийн идэвхжил саарч байгаагийн том дохио хэмээн шинжээчид үзэж байгаа бөгөөд бодлогын хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн дохио болов.

- 2019/06/25 - Иран Улс болон АНУ хоорондын харилцаа огцом муудаж Ойрх дорнодын аюулгүй байдал хүндэрсэн, Их Британи Улсын шинэ Ерөнхий сайд хэн болох нь тодорхой бус, Хонг Конг хотод эх газарлуу хэрэгтэн шилжүүлэх хуулийг эсэргүүцсэн том хэмжээний бослого гараад байгаа зэрэг үйл явдлууд дэлхий дахинд геополитикийн эрсдэлийг нэмэгдүүлж алтны ханш огцом өслөө.
- 2019/07/01 - 6-р сарын 28, 29-ний өдрүүдэд болсон "ИХ 20"-ийн уулзалтаар худалдааны маргаанд нааштай үйл явдлууд болж, сүүлийн саруудад уналттай байсан хөрөнгийн зах зээлд сэргэлт гарч эхлэв. Учир нь уулзалтын үеэр Д.Трампын болон Ши Жинпин нар худалдааны маргааны талаар хэлэлцэн, хэлэлцээрийг дахин үргэлжлүүлэхээр болсон. Үүний хүрээнд АНУ-ын зүгээс Huawei-д тавьсан хоригоо цуцлах, нэмж \$325 тэрбумын бараанд тариф ногдуулахгүй байхаар тохиролцов. Хариуд нь БНХАУ АНУ-аас импортлох хүнсний ногооны худалдааг дэмжихээ мэдэгдэв.
- 2019/07/18 - Иран Улсын дроныг АНУ-ын байлдааны хөлөг онгоц буудан унагааж, Иранд үүсээд буй нөхцөл байдал улам даамжирч газрын тосны нийлүүлэлт тасалдах эрсдэл үүссэн. ХНБ бодлогын хүүг 7 дугаар сарын эцсийн хурлаар 50 хүртэл суурь нэгжээр бууруулах хүлээлттэй байсан. Улмаар АНУ-ын мөнгөний бодлого цаашид сулрах, ам.долларын ханш буух нөхцөл байдал үүсээд байлаа.
- 2019/07/31 - ХНБ 7-р сарын 30-31-ний өдрүүдэд болсон Нээлттэй захын зөвлөлийн хурлаар бодлогын хүүгээ 25 суурь нэгжээр буурууллаа. Энэ нь 2008 оны их хямралаас хойш бодлогын хүүгээ буулгаж байгаа анхны тохиолдол юм. Гэсэн хэдий ч цаашид мөнгөний зөөлөн бодлого үргэлжлэх талаар тодорхой чиглэл өгөөгүй нь мөнгөжсөн алтны үнэ буурахад нөлөөлөв.
- 2019/08/01 - Шанхай хотноо хоёр орны төлөөлөгчид худалдааны маргааны асуудлаар ээлжит уулзалтыг 7-р сарын 31-нд хийв. Уг уулзалтын дараагаар Трамп БНХАУ-аас импортлох 300 тэрбум ам.долларын бараанд нэмэлт 10%-ийн татварыг 9-р сарын 1-ний өдрөөс эхлэн ноогдуулахаар болоод байна. Учир нь БНХАУ "Их 20"-ын уулзалтын үеэр АНУ-аас импортлох хөдөө аж ахуйн барааны худалдааг дэмжинэ гэсэн тохиролцоондоо хүрээгүй, мөн хэлэлцээрийн нөхцлийг дахин хэлэлцэх хүсэлт

тавьсны улмаас уг шийдвэрийг гаргах болсон хэмээн мэдэгдлээ.

- 2019/08/07 - Хятадын ардын банкнаас юанийн ам.доллартай харьцах ханшийг 7-гоос хэтрүүлэлгүй хатуу барьдаг байсан БНХАУ-ын эрх баригчид ханшийг суллаж, зориудаар унагасан нь сүүлийн 11 жилийн түүхэнд анхны тохиолдол боллоо. Ингэснээр БНХАУ-ын тарифын арга хэмжээнээс үүдэн экспортод ирэх дарамтыг бууруулж байна. Энэхүү явдлыг Трамп харахдаа Хятадууд юанийн ханшаар тоглож, "currency manipulator" буюу валютын ханшийг удирдах замаар гадаад худалдаанд өөртөө давуу тал бий болгох гэж байна хэмээн мэдэгдсэн. Ингэснээр АНУ-ын хөрөнгийн зах зээлийн гол индексүүд огцом унаж, энэ оны хамгийн доод хэмжээндээ хүрсэн бол алтны ханш огцом өсөхөд нөлөөлөв.
- 2019/08/13 - Хонг Конг Улсад 10 долоо хоногийн турш өрнөж буй жагсаалын байдал хүндэрч, олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг бүрэн зогсооход хүрэв. Мөн Аргентин Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн үр дүн урьдчилан таамаглаж байснаас өөр байсан нь эдийн засагт шок өгч, хувьцааны зах зээл 30 хувиар буурсан, үндэсний мөнгөн тэмдэгт песо 36 хувиар суларсан зэрэг сөрөг үр дүнд хүргэв. Уг эрсдэлүүд нь алтны үнэ сүүлийн 6 жилийн дээд хэмжээнд хүрч өсөхөд голлон нөлөөлөв.
- 2019/08/14 - АНУ-ын Ерөнхийлөгч Трамп БНХАУ-ын 265 тэрбум ам.долларын бараанд импортын нэмэлт тариф ноогдуулахаар шийдвэрлэсэн байсан боловч 156 тэрбум ам.доллартай тэнцэх электрон бараа, тоглоом зэрэг зарим барааны хувьд тус нэмэлт татвараа хойшлуулан, 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс хэрэгжүүлж эхлэхээ мэдэгдэв. Учир нь уг гэнэтийн шийдвэрээс шалтгаалан БНХАУ-аас бараа импортлодог АНУ-ын компаниудад их хэмжээний хохирол үүсэх өндөр магадлалтай байсан. Иймд худалдааны компаниудын хамгийн идэвхитэй улирал буюу баярын улирлыг тооцоолон худалдааны тарифын арга хэмжээг түр хугацаагаар хойшлуулаад байна. Худалдааны маргааны хурцадмал асуудал түр хугацаанд шийдэгдсэнээр алтны ханш эргэн буурч эхлэв.

Томоохон орнуудын хооронд гадаад худалдааны асуудал үүссэн, улс орнуудын Төв банкууд бодлогын хүүгээ бууруулж эхэлсэн, геополитикийн тодорхой бус байдал хадгалагдсаар байгаа зэрэг эрсдэлийг тооцоолон зах зээлд оролцогчид өндөр эрсдэл хүлээж байгаа учир алтны эрэлт нэмэгдэж, ханш өсөх хандлагатай байна.

Б.ЖАВХЛАН: ҮНДСЭН ХУУЛЬД ТӨВ БАНКНЫ БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ТУНХАГЛАХ НЬ МАШ ЧУХАЛ

*УИХ-ын гишүүн Б.Жавхлантай
Монголбанкны хараат бус байдлыг Үндсэн
хуулиар баталгаажуулах нь ямар ач
холбогдолтой болох талаар ярилцлаа.*



Төв банкны хараат бус байдлыг Үндсэн хуульдаа тусгасан улс орнууд байдаг шүү дээ. Манай улсын хувьд одоо хэлэлцэж байгаа Монгол Улсын үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд Монголбанкны бие даасан хараат бус байдлыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөс оруулсан төсөлд тусгасан байсныг та хэрхэн хүлээн авах вэ?

Монгол Улс 1990 онд шинэ нийгэмд орсноор банкны хоёр шатлалт тогтолцоонд шилжиж, төв банкттай болсон. Мөн хөрөнгийн биржтэй болж, өмч хувьчлал явагдсан. Энэ том өөрчлөлтийн хамгийн оргил хэсэг нь бид төв банкттай болсон явдал. Өнгөрсөн 29 жилийн хугацаанд төв банк маань

өөрийгөө их сайн боловсруулж, бие даасан хараат бус байдлаа чанаржуулж ирсэн. Төв банкны тухай хууль болон Банкны тухай хуулиудаа улам сайжруулсаар ирсэн. Харин одоо Үндсэн хуульд оруулж байгаа өөрчлөлтүүд дунд төв банкны хараат бус бие даасан байдлыг тунхаглаж өгвөл улам л сайн үр дүн авчирна. Гэхдээ Үндсэн хуульд төв банкны хараат бус байдлын талаар заалт оруулснаар бие даасан байдал бүрэн хангагдана гэвэл бас өрөөсгөл. Үүнийг хангаж өгөхийн тулд Үндсэн хуулиас гадна органик хуулиудад энэ шаардлагыг сайн хангаж өгөх ёстой. Ялангуяа төв банкны тухай хууль, банкны тухай хууль, валютын зохицуулалтын тухай хууль, монополийн эсрэг хууль

гэх мэт. Эдгээр хуульд төв банк өөрийнхөө үүргийг биелүүлэхдээ Засгийн газраас хараат бус, улс төрөөс хараат бус, бие даасан шийдвэрийг гаргаж чаддаг байх, түүнийхээ дагуу ч бие даасан хариуцлагаа хүлээж чаддаг байх маш сайн зохицуулалттай болгож өгөх хэрэгтэй. Хамгийн зөрчилтэй байдаг асуудал нь төв банк үнийн тогтвортой байдлыг хянах юм уу, үгүй бол ханшийн тогтвортой байдлыг хянах юм уу гэдэг асуудал бий. Манай улсын банк тойрсон эрх зүйн тогтолцооны хамгийн том гажуудал нь энэ шүү дээ.

Тодруулбал?

Хэрэв төв банк гадаад худалдааны асуудлыг эрхэлдэг, төлбөрийн балансыг хариуцаж,



Л.ПҮРЭВДОРЖ

(Үндсэн хууль батлалцсан Ардын Их Хурлын Депутат, УИХ гишүүн, Монголбанкны Ерөнхийлөгч асан)

хянадаг, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, эрүүл мэндийн бүхий л салбарыг хариуцаж, хянадаг байсан бол төв банк дангаараа валютын ханшийн асуудлыг хариуцаж болно. Гэтэл энэ чинь өөрөө Засгийн газрын л асуудал. Төв банк бол зөвхөн нөөцийн удирдлагыг хийнэ. Гэтэл Төв банкны тухай хуулиндаа үнэ болон валютын ханшийг хамтад нь оруулаад өгчихсөн. Валютын зохицуулалтын тухай хуулийг хариуцахаар 50, 50 хувьтай, бүрэн зааглаж өгч чадаагүй байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, төв банк зарим тохиолдолд Засгийн газрын өмнөөс улс төрийн хариуцлага хүлээдэг. Засгийн газар асуудлаа төв банк руу явуулчихдаг. Үүнээс нь болоод төв банк бодлогын эрсдэлд орж эхэлдэг. Зарим тохиолдолд ханшийн хэлбэлзэл бус бүр улс төрийн хэлбэлзлийг намжаах зорилгоор валютын зах руу ордог тохиолдол олон гарч байсан. Энэ нь төв банк хараат бус байж чадахгүй байгаагийн хамгийн том илрэл. Тэгэхээр Үндсэн хуулиас гадна органик хуулиудад төв банкны бие даасан, хараат бус байдлыг хангаж өгөх өөрчлөлтүүдийг маш сайн хийж өгөх хэрэгтэй. Өнөөдрийг хүртэл энэ бүрэн хийгдэж чадаагүй байна. Хамгийн сүүлд 2018 онд Төв банкны тухай хуулийн өөрчлөлтөөр Үндсэн зорилтыг Үнийн тогтвортой байдал гэж тодорхойлсон боловч харамсалтай нь Их хурлын босгыг давж чадаагүй.

Тэгэхээр таны хувьд Үндсэн хууль гэхээсээ илүү органик хуулиудад нарийн зохицуулалт хийх шаардлагатай гэж үзэж байна уу?

Ер нь бол Үндсэн хуулинд

Үндсэн хуульд өөрчлөлт оруулах гол зорилгыг манай улсын тогтвортой, урт хугацааны, хүртээмжтэй, алсыг харсан хөгжлийг хангах гэж харж байгаа. Өнөөдөр яагаад эдийн засаг савлаад, эсвэл шударга бус явдал байна вэ гэхээр улс орны бүхий л амьдрал, эдийн засгийн хөгжилд нам, бүлэглэлийн оролцоо хэтэрхий их болчихоод байгаа юм. Улс төрийн нам, улстөрчид дөрвөн жилийн хугацаанд яаж дахин сонгогдох вэ гэдгээ л бодож ажиллаж байна. Тийм учраас улс орны ирээдүйг харсан бодлого нь үндсэндээ “орон гаран” болчихоод байгаа юм.

Тэгэхээр эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангахын тулд нэг талаас Үндсэн хуулиар төсвийн бодлогын бие даасан байдлыг хангах, “76 Сангийн сайд” байхыг хязгаарлах, мэргэжлийн Засгийн газар үүргээ биелүүлж, хариуцлага хүлээх чиглэлийн заалтууд оруулж өгсөн нь амин чухал зүйл. Ингэснээр төсвийн тогтвортой байдлыг хангаж болох ч нөгөө талд мөнгөний бодлогын талыг орхигдуулбал, эдийн засгийн бодлого маань доголдоно. Эдийн засгийн бодлогын нэг хөл нь бат бэх, нөгөө хөл нь доглон болно. Нөгөө талаас Үндсэн хуульд оруулж байгаа өөрчлөлт нь гүйцэд, сайн болж чадахгүй. Тийм учраас мөнгөний бодлогын бие даасан байдлыг хангаж, мөнгөний бодлого руу улстөрчид, нам, мэргэжлийн бус

хүмүүсийн оролцоог багасгах ёстой. Үүний тулд болж өгвөл одоогийн Үндсэн хуульд байгаа “Төрийн мөнгөний бодлогын Үндсэн чиглэлийг УИХ-аас батална” гэсэн заалтыг хасах ёстой. Хасдаггүй юм гэхэд ямар заалт нэмэх ёстой вэ гэхээр “Монгол Улсын төрийн мөнгөний бодлогыг Монголбанк хараат бусаар, бие даан хэрэгжүүлнэ” гэдэг өгүүлбэрийг л тусгаж өгөх ёстой. Үүнийг баталгаажуулахын тулд “Монголбанкны Ерөнхийлөгчийг УИХ-аас 6 жилээр томилно” гэсэн хоёр заалт л хэрэгтэй байна.

Яагаад гэвэл мөнгөний бодлогыг УИХ хэлэлцэхээр “76 Монголбанкны Ерөнхийлөгч” бий болчих гээд байдаг. Хоёрдугаарт, Монголбанк мөнгөний бодлогоо сайн, муу хэрэгжүүлж байна гээд л мөнгөний бодлогод улстөрчид оролцох хөшүүрэг нь болох гээд байгаа юм. Нөгөө талаас улстөрчид мөнгөний бодлогод оролцож, намчирхаж байгаа гол зүйл нь юугаар дамжиж гарч ирдэг вэ гэхээр ялсан нам нь Монголбанкны Ерөнхийлөгчийг сольдог жишигтэй болчихсон шүү дээ. Энэ байдлыг засахгүйгээр одоогийн хийгдэж байгаа өөрчлөлт нь эдийн засгийн бодлогыг тодорхойлох, тогтвортой сайн болгох чиглэлд хангалттай сайн үүргээ гүйцэтгэж чадахгүй. Монгол Улсын макро эдийн засгийн бодлого доглон л үлдэх байх.

төв банкны асуудлыг оруулж, бие даасан, хараат бус байдлыг тунхаглах нь маш зөв. Тэгж чадвал дараагийн шатны органик хуулиуддаа өөрчлөлт оруулахад илүү дөхөм болох юм. Үндсэн хууль өөрөө их том институци. Үндсэн хуулинд органик хуулиудад

байдаг шиг детальчилсан асуудлыг оруулах боломж байхгүй. Маш зөв, олон жилийн, урт настай тунхаг заалтуудыг л Үндсэн хуульд оруулж өгөх ёстой. Үүнийхээ дагуу органик хуулиуддаа нарийвчилсан зохицуулалтуудыг сайн тусгаж өгөх нь зөв юм.



Өнгөрсөн 29 жилийн хугацаанд төв банк маань өөрийгөө их сайн боловсруулж, бие даасан хараат бус байдлаа чанаржуулж ирсэн. Төв банкны тухай хууль болон Банкны тухай хуулиудаа улам сайжруулсаар ирсэн. Харин одоо Үндсэн хуульд оруулж байгаа өөрчлөлтүүд дунд төв банкны хараат бус бие даасан байдлыг тунхаглаж өгвөл улам л сайн үр дүн авчирна.



Төв банкны үүрэг ханш уу, үнийн тогтвортой байдал уу гэдэг хоёр ойлголтыг нэг мөр болгож, нэг талд нь гаргах шаардлага байсаар л байна гэж та үзэж байна уу?

Үүнийг нэг тал руу нь гаргах сонирхолгүй улс төрийн хүчин их байна. Ямар нэгэн макро хүчин зүйл гарч ирвэл Засгийн газрын талд улстөрчид ажиллаж байгаа учраас өөрсдөөсөө холдуулахыг хүсдэг. Үүнийг нь дааж, өөр дээрээ үүрч байх институци хаа нэгтээ байж байх хэрэгтэй байх. Тэр нь төв банк болж хувирчихаад байгаа юм.

Тэгэхээр төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг жил бүр бус 3 жилд нэг удаа Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, батлуулж байх тухай санал бий. Та энэ талаар ямар байр суурьтай байна вэ?

УИХ-ын бүрэн эрхийн хугацаа 4 жил байгаа нөхцөлд Төв банк Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлээ 3 жилээр батлуулах нь оновчгүй, хугацааны хувьд их хурлаасаа холдчих юм болов уу. Жил бүр хэлэлцээд, батлаад явлаа гээд буруудах зүйлгүй. Энэ бол боломжтой хугацаа гэж үзэж байна. Эцсийн дүндээ төв банкны үйл ажиллагааг гажуудуулахад чиглэсэн зүйлийг аль ч Их хурал дээр хийгээд байдаггүй. Хэлэлцэх шатанд янз бүрийн санал, асуудлууд гарч ирдэг. Эцсийн шатанд төв банкны өөрийнх нь хариуцдаггүй, хуулиас гажсан үүрэг чиглэл өгдөггүй. Тэртээ тэргүй хуулинд нь төв банк ханш болон инфляцийг хариуцна гээд тусгачихсан. Тэр хүрээндээ л Их хурал асуудлаа ярьдаг.

Төгсгөлд нь асуухад та төв банкны сүүлийн 3 жилийн бодлогын хэрэгжилтийн үр дүнг хэрхэн харж байна вэ?

Төв банк сүүлийн 3 жилийн хугацаанд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн чиглэлийнхээ дагуу хангалттай түвшинд ажиллаж байна. Ялангуяа хууль, эрх зүйн орчны реформуудыг амжилттай хийлээ. Үүгээрээ төв банкны бие даасан хараат бус байдлаа сайжруулах, банкуудад тавих анхаарал, хяналтаа сайжруулж, илүү ил тод, үр дүнтэй арга хэмжээ авах, төсөвт хүндрэлгүйгээр шийдэх, арилжааны банкны хөрөнгө оруулагчдыг өөрсдийг нь хариуцлагажуулах болсон зэрэг нь чухал үр дүнтэй юм. Гэх мэтээр төв банкны ажил, асуудлууд маш тодорхой байгаа шүү дээ. Мөн Монголбанк Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд инфляцийг зорилтод түвшинд барихаар тооцож тусгасных нь дагуу инфляци сүүлийн 3 жилд яг л зорилтот түвшиндээ байгаа учраас төв банк хангалттай ажиллаж чадаж байгаа.

1994 ОНЫ ГҮЙЛГЭЭНИЙ ЗООСОН ТӨГРӨГ БОЛОН ЦААСАН МӨНГӨ

1994 онд 20, 50, 100, 200 төгрөгийн дөрвөн төрлийн нэрлэсэн үнэтэй зоосыг "зоос гоёлын" үйлдвэрт үйлдвэрлэж гүйлгээнд гаргажээ.





ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН ТӨВ БАНКНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Д.ГАНГАБААТАР*

JEL ангилал:

E

Түлхүүр үг:

Үндсэн хууль, Төв банк,
эрх зүйн зохицуулалт, бие
даасан байдал

Хураангуй:

Энэ өгүүлэлд Үндсэн хуулиар Төв банкны үйл ажиллагааг зохицуулах харилцаа, шаардлага, ач холбогдол, үр нөлөөний талаар гадаад улс орнуудын туршлагад тулгуурлан өгүүлсэн болно. Сүүлийн гуч орчим жилийн хугацаанд Төв банкны үйл ажиллагааг Үндсэн хуулиар зохицуулах асуудал дэлхийн улс орнуудад өргөжиж ирлээ. Төв банкны статус, бие даасан байдал, зорилго, эрх мэдлийн салаа мөчрүүдтэй харилцах харилцаа зэрэг олон төрлийн зохицуулалтын үндсийг Үндсэн хуульд тусгах болсон. Учир нь дээд эрэмбийн хуульд Төв банкны эрх зүйн зохицуулалтын суурийг хуульчлах нь түүний бие даасан байдал, тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлдэг ажээ.

1. Төв банкны эрх зүйн зохицуулалт: Олон улс, бүс, үндэсний хэмжээнд зохицуулах нь

Монгол Улсын Үндсэн хуульд хувийн өмчийн институцийг баталгаажуулж, олон хэвшил бүхий эдийн засагтай байхаар хуульчилсан¹ хэдий ч Төв банкны эрх зүйн зохицуулалтын талаар Үндсэн хуульд шууд тусгаагүй билээ. Харин дэлхийн улс орнуудад Төв банкны үйл ажиллагааг үндэсний хууль тогтоомжийн хүрээнд зохицуулахаас гадна бүсийн болон олон улсын гэрээ хэлэлцээрээр зохицуулж иржээ. Тухайлбал, Европын холбоонд нэгдэхийн тулд Төв банкны бие даасан байдлыг хуулиар хамгаалсан байх шаардлагыг Маастрихтын гэрээнд тусгасан байдаг.

Үндэсний эрх зүйн хувьд эрх мэдэл, чиг үүрэг, бие даасан байдлын эрх зүйн зохицуулалтын суурийг Үндсэн хуульд тусгаж, Төв банкны тухай хуулиар дэлгэрүүлэн зохицуулах явдал түгээмэл байна. Чиг үүрэг, өмч, эрх мэдэл, хязгаарлалт, үйл ажиллагааны цар хүрээ, томилгоо, бие даасан байдал зэрэг Үндсэн хуулиар зохицуулах харилцаа нь улс оронд харилцан адилгүй байх нь тухайн улс орны эдийн засгийн бодлогоос гадна улс төрийн орчин, нөхцөлөөс хамааралтай байдаг. Мөн тодорхой шийдвэр гаргах эрх, тухайлбал, төлбөр, торгууль ногдуулах эрхийг Төв банкинд Үндсэн

* МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор

¹ Монгол Улсын Үндсэн хууль, 1992, 5.1 дүгээр зүйл.

хуулиар олгох нь бий. Энэ бүрэн эрх нь банкныг хянах, заавал байлгах нөөцийг хангасан эсэхэд хяналт тавих тохиолдолд шаардлагатай байдаг.² Мөн Төв банкны бие даасан байдлыг олон орны Үндсэн хуульд тусгасан байдаг. Үүнийг зарим Үндсэн хуульд бие даасан байдал “independence”, заримд нь “autonomous” хэмээн томъёолсон байна. Либекийн үзсэнээр бие даасан байдал гэдэг нь институцийн хувьд гадна, дотны нөлөөнөөс ангид байх, харин “autonomous” гэдэг нь үйл ажиллагааны хувьд чөлөөтэй байх гэж тайлбарлажээ.³

Төв банкныг Үндсэн хуулиар зохицуулдаг эсэх нь тухайн улс аль эрх зүйн бүлд багтдагаас тодорхой хэмжээнд хамааралтай байна. Төв банкны засаглалын талаар хийсэн судалгаанд эх газрын эрх зүйн бүлд хамаарах тавин долоон улсаас гуч нь Төв банкны үйл ажиллагааг Үндсэн хуулиар зохицуулсан байна.⁴ Харин нийтлэг эрх зүйн бүлд хамаарах арван гурван улсаас нэг нь ч Үндсэн хуульд Төв банкинд шууд хамаарах зохицуулалт тусгаагүй байна. Мэдээж эдгээр дотор Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс, Шинэ Зеланд зэрэг бичмэл Үндсэн хуульгүй улс орон багтаж

² Төв банкны тухай Монгол Улсын хууль, 1996, 12.5 дугаар зүйл.

³ Lybek, T., 2004, “Central Bank Autonomy, Accountability, and Governance: Conceptual Framework,” IMF Legal Department Seminar August 2004.

⁴ BIS, 2009, Issues in the Governance of Central Banks – A Report from the Central Bank Governance Group (Basel: Bank for International Settlements)

байна. Харин холимог эрх зүйн бүлд хамаарах гучин улсаас зөвхөн дөрвөн улс л Үндсэн хуульд Төв банкны талаар тусгасан байна.⁵ Эндээс Төв банкны эрх зүйн зохицуулалтын үндсийг Үндсэн хуулиар тавих нь эх газрын эрх зүйн тогтолцоотой улсад түгээмэл практик болох нь харагдаж байна.

Үүний шалтгаан нь нийтлэг эрх зүйн бүлтэй харьцуулахад эх газрын эрх зүйн тогтолцоон дахь хууль, эрх зүйн гол эх сурвалж нь Үндсэн хуульд нийцүүлэн баталсан бичмэл хууль, тогтоомж байдагтай холбоотой юм. Үндсэн хуулийн зохицуулалт нь Төв банкныг Үндсэн хуулийн байгууллага болгож, түүний бие даасан байдал, статусыг баталгаажуулах ач холбогдолтой билээ. Ингэснээр түр хугацаанд төрийн эрхэнд гарсан улс төрийн хүчин, бүлэглэл, хувь хүмүүс, улс төр, хувийн ашиг сонирхлоор Төв банкныг ашиглахаас сэргийлдэг байна. Мөн түр хугацааны улс төр, эдийн засгийн дарамт, шахалтаас болж, эсхүл улс төрийн дэмжлэг авах зорилгоор үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн зүгээс Төв банкинд үзүүлэх нөлөөллийг багасгах үр нөлөөтэй ажээ.

Төв банкныг байгуулах, статусыг тодорхойлох, бүтцийг тогтоох, бие даасан байдлыг нь баталгаажуулах, зорилгыг тодорхойлох, Засгийн газарт зээл олгохыг хориглох, албан хаагчийг томилох болон огцруулах үйл явцын хэм хэмжээг тогтоох зэрэг Төв банктай холбоотой олон төрлийн эрх зүйн зохицуулалтыг Үндсэн хуульд тусгадаг. Эдгээрээс аль төрлийн зохицуулалтыг Үндсэн хуульд тусгах нь тухайн улс орны сонголтын асуудал юм. 2008 оны санхүүгийн хямралаас хойш олон оронд санхүүгийн тогтвортой байдлын талаар хуульд тусгах болжээ.⁶

Европын холбооны улс орнуудын хувьд Үндсэн хуульд Төв банкны талаарх дараах асуудлыг хуульчилсан байна. Үүнд: Төв банк байгуулах тухай;⁷ Төв банкны бүтэц;⁸ бие даасан байдал;⁹ тусгай хуулиар зохицуулах тухай; Төв банкны зорилго;¹⁰ мөнгөний бодлогын зорилго; Засгийн газарт зээл олгохыг хориглох;

⁵ Мөн тэнд.

⁶ BIS, 2011, Central Bank Governance and Financial Stability, (Basel: Bank for International Settlements).

⁷ Армен, Чех, ХБНГУ, Унгар, Мексик, Польш, ОХУ, Швед г.м.

⁸ Польш, Словак, Швед г.м.

⁹ Dincer, N., and Barry Eichengreen (2014). "Central Bank Transparency and Independence: Updates and New Measures," International Journal of Central Banking, vol. 10 (March), pp. 189-253.

¹⁰ ХБНГУ, Мексик г.м.

томилох, огцруулах талаар; хэний өмнө хариуцлага хүлээх, хэнтэй зөвшилцөх зэрэг зохицуулалтыг тусгажээ.

Үндсэн хуулиараа Төв банкинд эрх мэдэл олгосон ч Засгийн газраас хараат бус байх эрх зүйн зохицуулалтыг хийж өгөөгүй улс ч байна.¹¹ Бразилаас гадна Япон улс Банкны тухай хуульд 1997 онд оруулсан зохицуулалтаар "Японы Банкны мөнгөний бодлого болон Засгийн газрын эдийн засгийн бодлого нь харилцан нийцтэй байх үүднээс байнгын харилцаа холбоотой байж, санал бодлоо солилцох ёстой тухай" тусгасан байна.¹² Ийнхүү Японы Банк чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Засгийн газартайгаа зайлшгүй санал солилцож, хамтарч ажиллах үүргийг ногдуулсан байна. Энэ зохицуулалтыг тайлбарлахдаа Япон улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлд Засгийн газрын танхимд гүйцэтгэх эрх мэдлийг бүрэн хуваарилсан тул мөнгөний бодлогын асуудлаар шийдвэр гаргах эрх нь энэ бүрэн эрхэд тодорхой хэмжээнд хамаарна гэж үзсэнтэй холбоотой гэдэг.

Нэг бус улс орны Төв банк мөнгөний бодлогыг хариуцдаг. Тухайлбал, Европын Төв банк харьцангуй сүүлд байгуулагдсан бол Баруун Африкийн улсуудын Төв банк,¹³ Төв Африкийн улсуудын Банк¹⁴ зэрэг нь бүр 1959 онд байгуулагдсан юм. Мөн Зүүн Карибад 1950 онд байгуулагдсан Зүүн Карибын Төв банкныг дурдаж болно. Сүүлийн жилүүдэд Өмнөд Африк, Ойрх Дорнодод ч гэсэн ийм төрлийн эвлэл, нийгэмлэг байгуулах асуудал хөндөгдөж байна.

Иймэрхүү хэд хэдэн улсыг хамарсан Төв банк нь аль нэг улсын Төв банкны гүйцэтгэдэг чиг үүргийг бүхэлд нь, эсхүл заримыг нь эдэлдэг. Тухайлбал, Европын холбооны Төв банк мөнгөний бодлого боловсруулах асуудлыг бүхэлд нь хариуцдаг бол гишүүн орны үндэсний Төв банк нь банкны үйл ажиллагааг хянах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Аливаа улсын Төв банк зөвхөн нэг институц бус хэд хэдэн институцийн нэгдэл хэлбэрээр үйл ажиллагаа явуулах нь бий. АНУ-ын Холбооны нөөцийн систем нь Вашингтонд байрлах Засаг даргын Зөвлөл болон

¹¹ Бразил улсын Үндсэн хууль, 164 дүгээр зүйл.

¹² Япон улсын Банкны тухай хууль, 4 дүгээр зүйл.

¹³ Баруун Африкийн Эдийн засаг, мөнгөний эвлэл нь баруун Африкийн зургаан орон (Бенин, Буркино Фасо, Мали, Нигер, Сенегал, Того г.м.)-ыг хамардаг.

¹⁴ Төв Африкийн Эдийн засаг, мөнгөний нийгэмлэг нь төв Африкийн зургаан орон (Камерон, ӨАБНУ, Чад, Конго, Габон болон Экваторын Гуин)-оос бүрдэж байна.

бусад мужид байрлах Холбооны нөөцийн 12 банкнаас бүрддэг. Бразил, ХБНГУ, Канад зэрэг холбооны улсад байдаг Төв банкны муж болон бүсийн салбартай харьцуулахад АНУ-ын Холбооны нөөцийн банк нь тусгай хуулийн этгээдийн статустай байдаг. Тиймээс Төв банкны хэрэгжүүлдэг чиг үүргийг зөвхөн үндэсний эрх зүйн хүрээнд бус бүсийн болон олон улсын хууль, эрх зүйн актаар зохицуулдаг байна.

2. Үндсэн хуулиар зохицуулах үндэслэл

Төв банкны эрх зүйн зохицуулалтын үндсийг ямар хуулиар олгох нь Төв банкны үйл ажиллагаанд нөлөөтэй байдаг. Жишээлбэл, Засгийн газрын шийдвэрээр зохицуулдаг бол тогтворгүй, байнга өөрчлөгдөх нөхцөл бүрдэнэ. Харин Үндсэн хуулиар зохицуулсан тохиолдолд эрх зүйн үндэс суурь нь бат бэх тавигддаг. Улс төрийн болон бусад зохисгүй нөлөөнөөс Төв банкиг хараат бус байлгахын тулд ердийн хуулиар бус, харин Үндсэн хуулиар, эсхүл дийлэнх олонхийн саналаар өөрчлөгддөг органик хууль, мөн түүнчлэн олон улсын гэрээгээр баталгаажуулах шаардлагатай байдаг. Эдгээр дээд эрэмбийн хуулийг өөрчлөхөд тавигдах үйл явцын хатуу шалгуур нь Төв банкны эрх мэдэлд хөндлөнгөөс халдах зэрэг зохисгүй нөлөөллөөс хамгаалах учиртай ажээ.

Үндсэн хуулиар Төв банкинд эрх зүйн шаардлагатай, тогтвортой орчныг бүрдүүлж болно. Эдийн засгийн талаарх бидний ойлголт цаг хугацаа өнгөрөх хэрээр өөрчлөгдөж ирсэн. Тиймээс Үндсэн хуулиар юуг зохицуулах вэ? Ямар харилцааг зохицуулахгүй вэ? гэдгээ сайтар анхаарах нь чухал. Тухайлбал, байнга өөрчлөгдөж байдаг, уян хатан шийдвэр шаардсан зохицуулалтыг Үндсэн хууль мэтийн дээд эрэмбийн хуульд оруулах нь эрсдэлтэй байдаг. Жишээлбэл, инфляцийн түвшинг барихтай холбоотой зорилтот тоог Үндсэн хууль битгий хэл, ердийн хуульд ч тусгах нь асуудал л нэмнэ. Түүнчлэн, валютын ханшийг тогтоон барих зорилтыг хуульд тусгах нь мөн л шийдлээс илүү асуудал үүсгэнэ. Тиймээс Үндсэн хуульд зарчим, бүтэц, чиг үүрэгтэй холбоотой ерөнхий зохицуулалтыг тусгахаас байнгын өөрчлөлт шаардсан эрх зүйн зохицуулалтыг тусгах учиргүй юм.

Тухайн улс орны нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал зэргээс хамаарч ямар харилцааг хуулиар зохицуулах, алийг нь дүрэм журамд, алийг нь Үндсэн

хуульд тусгахыг шийднэ. Бичмэл Үндсэн хуультай эх газрын эрх зүйн тогтолцоотой улсын хувьд Төв банкинд хамаарах олон асуудлыг Үндсэн хуулиар зохицуулдаг. Европын холбооны хувьд Европын Төв банкны дүрмийг гишүүн улс нь бүрэн зөвшилцөлд хүрч байж баталсан олон талт гэрээгээр баталгаажуулсан тул энэ гэрээг хагас Үндсэн хуульжсан статус бүхий гэрээ ч гэдэг. Улс төрийн үйл явц нь тогтворгүй бөгөөд мөнгөний бодлогод сөргөөр нөлөөлөх хандлагатай улс орны хувьд Үндсэн хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үздэг.

Үндсэн хуульд тусгагдсан Төв банкны зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах нь олонх улсад хатуу шалгуур, парламентын зөвшилцөл шаардана. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Үндсэн хуулийн цэцийн саналыг авахыг шаарддаг нь Үндсэн хуульд зохисгүй нэмэлт, өөрчлөлт оруулахаас сэргийлэх зорилготой. Үүний нэгэн адил Үндсэн хууль дахь Төв банкны зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хэлэлцүүлэгт оролцуулах, чуулганы хуралдаанаар хэлэлцэхийн өмнө банкны саналыг авах зэрэг боломжоор хангах нь чухал.¹⁵ Европын олон улсад Төв банкны эрх зүйн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд хамтарсан ажлын хэсэг, эсхүл зөвлөлдөх хороо байгуулж ажиллах талаар сүүлийн үед тусгах болсон.¹⁶

Ердийн хууль дахь Төв банкны зохицуулалтыг УИХ дахь олонх хялбархан өөрчлөх боломжтой бөгөөд ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь олон нийтийн анхааралд төдийлөн хүрэлгүй өнгөрөх магадлал өндөр байдаг. Харин Үндсэн хуулийн түвшинд зохицуулснаар мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах Төв банкны үндсэн зорилтод саад тотгор учруулсан ердийн хууль тогтоомж, холбогдох шийдвэрийг Үндсэн хуулийн хяналтаар хүчингүй болгох нөхцөл бүрдэнэ.

Нөгөө талаас Үндсэн хуулиар Төв банкны харилцааг дэлгэрэнгүй зохицуулах нь Төв банкны эрх зүйн зохицуулалтын уян хатан байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Эдийн засаг, нийгмийн өөрчлөлтийг дагаад Төв банкны зохицуулалт өөрчлөгдөж байдаг. 2008 оны эдийн засгийн хямралын дараа дэлхийн олон улс орны Төв банкны эрх зүйн зохицуулалт өөрчлөгдсөн байдаг.

¹⁵ Европын холбооны Гэрээний 105.4-р зүйлд банкны эрх зүйн байдалд хамаарах зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал хөндөгдөхөд банкны саналыг авахыг шаарддаг.

¹⁶ Исланд, Швед, Швейцар г.м.

Тухайлбал, зорилгыг тодорхойлох, шийдвэр гаргах, хариуцлага, мэдээлэл цуглуулах гэсэн дөрвөн чиглэлээр томоохон өөрчлөлт орж байжээ.¹⁷ Тиймээс Төв банкны тухай Үндсэн хуульд хуульчлахдаа үзэл баримтлал, зарчмын шинжтэй зохицуулалтаар хязгаарлах нь эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалтай уялдуулан өөрчлөх, сайжруулах боломжийг нээлттэй үлдээх болно.

3. Эрх зүйн статус ба өмчийн асуудал

Төв банкны эрх зүйн статусыг Үндсэн хуулиар зохицуулсан улс олон бөгөөд эрх зүйн статус болон өмчийн хэлбэрийн хувьд улс орны хувьд ялгаатай байгаа нь голдуу тухайн улсын түүхээс улбаатай. Сүүлийн үед байгуулагдсан олон Төв банк төрийн өмчид байгаа бол хуучны зарим Төв банк хувийн өмчийн институт хэлбэрээр байгуулагдаж байсан бөгөөд одоо ч тэр хэлбэрээ тодорхой хэмжээнд хадгалсаар байна.

Зарим Төв банкны эрх зүйн статусыг Үндсэн хуулиар тодорхойлдог бол бараг бүх Төв банкиг тусгай хуулиар зохицуулдаг. Хуулиар Төв банкны чиг үүрэг, бүрэн эрх, хязгаарлалт, бүтэц гээд олон харилцааг зохицуулна. Дөчин долоон улсад хийсэн судалгаагаар тэдгээрийн дөчин гурван хувь нь төрийн өмчит корпораци, гучин найман хувь нь бие даасан Засгийн газрын институт, мөн арван зургаа орчим хувь нь компанийн хуулийн дагуу хувийн компани хэлбэрээр байгуулагдсан байна.¹⁸ Жишээлбэл, Швейцарийн Үндэсний банк нь компанийн хэлбэрээр байгуулагдсан бөгөөд Үндсэн хуулиас гадна компанийн тухай хуулиар зохицуулагдаж, харин албан хаагчид нь төрийн албаны тухай хуульд захирагддаг байна. АНУ-ын Холбооны нөөцийн систем дэх Захирагчийн зөвлөл нь төрийн өмчийн институт бол Холбооны нөөцийн банкнууд нь хувийн өмчид хамаарч хувьцааг нь арилжааны банк эзэмшдэг байна. Хувийн, төрийн, эсхүл холимог өмчийн эсэх нь эдгээр Төв банкны үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт нь төдийлөн нөлөөлөхгүй байна гэсэн дүгнэлт байдаг.

4. Үндсэн хууль дахь шууд болон шууд бус зохицуулалт

Үндсэн хуулиар зохицуулахдаа тодорхой бүрэн эрх, чиг үүргийг Төв банкинд хэрхэн олгодог тухай асуудалд

¹⁷ Ashraf Khan, Central Bank Legal Frameworks in the Aftermath of the Global Financial Crisis, IMF working paper, 2017, 7.

¹⁸ BIS, 2009, Issues in the Governance of Central Banks – A Report from the Central Bank Governance Group (Basel: Bank for International Settlements). 63.

анхаарал хандуулах ёстой. Чиг үүрэг, эрх мэдлийг Үндсэн хуулийн бичвэрт илтэд, шууд хуульчлахаас гадна хуулийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор буюу шууд бусаар зохицуулах нь Үндсэн хуулийн эрх зүйд нийтлэг байдаг.

Төв банкны тухай, холбооны Засгийн газраас банк байгуулж болох эсэх талаар АНУ-ын Үндсэн хуулийн бичвэрт шууд тусгагдаагүй боловч Үндсэн хуулиар зохицуулсан гэж үздэг. Мэрилэнд мужид Холбооны Засгийн газраас байгуулагдсан АНУ-ын Хоёрдугаар банк Үндсэн хуулийн бус гэж мужийн шүүх үзсэн байдаг. Харин холбооны Дээд шүүхийн шийдвэрт “Конгресс банк байгуулж болохоор Үндсэн хуульд шууд заагаагүй боловч Конгресст татвар авах, мөнгө зээлэх, мөнгөн тэмдэгт хэвлэх эрх олгосон”¹⁹ гээд АНУ-ын Үндсэн хуулиар дээрх бүрэн эрхээ хэрэгжүүлэх зохистой арга замыг сонгох эрхийг Конгресст нээлттэй үлдээсэн байна. Мөн өөрт нь Үндсэн хуулиар олгогдсон бүх эрх мэдлийг эдлэхэд шаардлагатай хуулийг батлах эрхийг олгожээ.²⁰ Иймд банк байгуулах эрхийг Үндсэн хуулийн бичвэрт шууд тусгаагүй ч шууд бусаар зөвшөөрч, зохицуулсан байна гэж үзсэн ажээ.²¹

Монгол Улсын Үндсэн хуульд төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлогыг тодорхойлох онцгой бүрэн эрхийг УИХ-д олгожээ.²² Мөн тэдгээр онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоохоор заасан байна. Үндсэн хуулийн эдгээр заалтаас үзвэл Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын Төв банкны бүрэн эрх, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн байна гэж дүгнэж болохоор байна.

5. Үндсэн хууль дахь хязгаарлалт

Үндсэн хуулиар банкны бүрэн эрхийг тодорхойлоод зогсохгүй хүлээх үүрэг хариуцлагыг ч хуульчилдаг. Хувьцаа эзэмшигч нь Төв банкны бодлого, банкны санхүүжилт зэрэгт нөлөөлөх нөлөөг хязгаарлах, удирдах албан хаагчийн бусад санхүүгийн байгууллагад ажиллах, тодорхой үйл ажиллагаа эрхлэх боломжийг

¹⁹ АНУ-ын Үндсэн хууль, 1787, 1.8.5-р зүйл.

²⁰ Мөн тэнд., 1.8.18 дугаар зүйл.

²¹ McCulloch v. Maryland, 1819, АНУ-ын Дээд шүүхийн хуралдааны тэмдэглэл, 267.

²² Монгол Улсын Үндсэн хууль, 1992, 25.1.7 дахь зүйл.

хязгаарлах, улс төрийн албан тушаалд өрсөлдөхийг хориглох зэрэг олон төрлийн хязгаарлалт байдаг.

Эдгээрээс нэн чухал хязгаарлалт бол Төв банк нь Засгийн газраас хараат бус байх тухай юм. Төв банкны хараат бус байдлыг хангах зорилгоор Засгийн газраас аливаа хэлбэрээр Төв банкинд чиглэл өгөхийг хориглодог. Жишээлбэл, Мексик улсын Үндсэн хуульд аливаа албан тушаалтан, эрх мэдлийн байгууллага Төв банкинд санхүүжилт олгох чиглэл, тушаал өгөхийг хориглоно гэжээ.²³ Европын Төв банк нь Засгийн газар, гишүүн улс, үндэсний Төв банк зэрэг ямар ч байгууллагаас чиглэл, заавар авахгүй гэжээ.²⁴ Мөн Засгийн газарт зээл олгох, Засгийн газрын үнэт цаасыг худалдан авахыг хязгаарлах зохицуулалт түгээмэл байна. Засгийн газрыг санхүүжүүлснээр мөнгөний бодлогод харшлах нөхцөл үүсгэхгүйн тул энэхүү хязгаарлалтыг тавьдаг нь бүрэн хязгаарлах,²⁵ тоон хязгаарлалт, зорилгоор хязгаарлах зэрэг олон төрөлтэй байна.

6. Дүгнэлт

Зарим талаар эрх зүйн бүлгийн онцлогоос хамаарч Төв банкиг Үндсэн хуулиар зохицуулах нь улс орнуудын хувьд ялгаатай байна. Төв банкны зорилго, чиг үүрэг, бодлого боловсруулах, бодлогын шийдвэр гаргах, тэдгээр шийдвэрээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бие даасан байдлыг баталгаажуулахад Үндсэн хуулийн зохицуулалт чухал үүрэгтэй. Төв банкиг улс төрөөс хараат бус, чиг үүргээ хэрэгжүүлэх, тогтвортой байх эрх зүйн боломжийг Үндсэн хуулийн зохицуулалт олгодог байна. Төв банкиг Үндсэн хуулиар шууд зохицуулсан улс олон бий. Харин шууд бусаар зохицуулсан улс орон нь Монгол Улсыг оруулаад түүнээс ч олон байна. Шууд бус зохицуулалт нь Үндсэн хуулийн үзэл баримтлал, зарчим, тодорхой төрийн институцэд олгосон эрх мэдлийг хэрэгжүүлэхтэй холбоотой Үндсэн хуулийн тайлбараар илэрч байна гэж үзэж болох юм.

Ном зүй:

1. Lybek, T., 2004, "Central Bank Autonomy, Accountability, and Governance: Conceptual Framework," IMF Legal Department Seminar August 2004.
2. Dincer, N., and Barry Eichengreen (2014). "Central Bank Transparency and Independence: Updates and New Measures," International Journal of Central Banking, vol. 10 (March).
3. BIS, 2009, Issues in the Governance of Central Banks – A Report from the Central Bank Governance Group (Basel: Bank for International Settlements).
4. BIS, 2011, Central Bank Governance and Financial Stability, (Basel: Bank for International Settlements).
5. McCulloch v. Maryland, 1819, АНУ-ын Дээд шүүхийн хуралдааны тэмдэглэл.
6. Ashraf Khan, Central Bank Legal Frameworks in the Aftermath of the Global Financial Crisis, IMF working paper, 2017.
7. Бразил улсын Үндсэн хууль, 1988.
8. Япон Банкны тухай хууль, 1997.
9. Мексик улсын Үндсэн хууль, 1917.
10. Лисбоны гэрээ, 2007.
11. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
12. Төв банкны тухай Монгол Улсын хууль, 1996.
13. АНУ-ын Үндсэн хууль, 1787.

²³ Мексик улсын Үндсэн хууль, 1917, 28 дугаар зүйл.

²⁴ Лисбоны гэрээ, 2007, 108 дугаар зүйл.

²⁵ Чили Улс, Лисбоны гэрээ, 2007, 101 дүгээр зүйл.



ТӨЛБӨР ТООЦООНЫ СИСТЕМ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД ХҮРЛЭЭ

Монголбанкнаас АСН+ нэртэй төлбөрийн системийн шинэчлэл хийснээр хүүхдийн мөнгөний гүйлгээг 5 минутад, ebarimt-ийн сугалааны мөнгийг 1 минутад боловсруулж чаддаг боллоо. Өөрөөр хэлбэл, урд нь тодорхой хугацааны хоцрогдол үүсч байж эдгээр гүйлгээ хийгддэг байсан бол одоо энэ бүх асуудал шийдэгдэж, төлбөр тооцооны гол шаардлагын нэг болох “түргэн шуурхай” ажиллагааг нэмэгдүүлэх боллоо.

Нийгмийн үүсэл хөгжилд тэр дундаа санхүү, төлбөр тооцоонд гарсан нэг том дэвшил бол мөнгөн шилжүүлгийн үйлчилгээ юм. Урд нь алт, мөнгөн зоос, гулдмайг нэг газраас нөгөө рүү зөөх гэж маш их цаг хугацаа зарцуулж, эрсдэл аюулыг даван туулдаг байсан бол цаг үеэ дагаад мөнгөн шилжүүлэг бий болжээ. Төлбөр тооцоонд гарсан энэ дэвшил нь үр ашигт байдлыг асар ихээр нэмэгдүүлж, олон улсын худалдааг интеграцчилж чадсан. Тухайлбал, хоёр орны хооронд худалдаа хийгдлээ гэхэд төлбөр гүйцэтгэх тоолонд мөнгө зөөдөг байсан бол банкны төлбөр тооцооны тусламжтай төлбөрийг тухай бүр нь гүйцэтгэхгүй зөвхөн өдөр, сар гээд тогтсон хугацааны эцэст багцалж, төлдөг болсон нь худалдаа, санхүүгийн салбарыг хүчтэй дэмжиж эдийн засгийн өсөлтийг тэтгэн, хүртээмжийг нэмэгдүүлсэн. Хүртээмжийн хувьд гэвэл хүн болгон төлбөр тооцооны данстай болсноор энэ их мөнгөн урсгалын нэг хэсэг болох боломж бүрдсэн юм.

АСН+ буюу автомат клиринг хаус систем нь бага дүнтэй буюу 3 сая төгрөг хүртэлх олон гүйлгээнүүдийг багцалж түргэн шуурхай шилжүүлдэг болсноороо онцлог билээ. Мөнгийг шилжүүлэх гэж 3 хоног болдог байсан бол яг ижил төрлийн гүйлгээ учраас багцалж 5 минутад л хийдэг болжээ. Өөр нэг чухал давуу тал бол олон улсын гүйлгээнд банкууд IBAN ашигладгийг Монгол Улс нэвтрүүлэх боломж бүрдсэн юм. Урд нь SWIFT гэдэг системийг зөвхөн банк тус бүр ашигладаг байсан бол одоо банкны данс тус бүр IBAN гэдэг кодтой болж бүх төрлийн гүйлгээ түргэн шуурхай, тодорхой болж байгаа юм. Энэ нь мөн төлбөр тооцоонд богино хугацааны үлдэгдэл хүрэлцэхгүй байх эрсдэлийг бууруулах буюу клиринг хаус гэдэг ойлголтыг бүрэн ашиглах боломж бүрдэх билээ. Өдөртөө их хэмжээний мөнгөн шилжүүлэг хийгддэг болсон энэ үед гүйлгээг нэг бүрчлэн хийх нь цаг хугацааны хувьд хохиролтой, нөгөө талаар мөнгө орж ирэх нь тодорхой байхад үлдэгдэл хүрэлцэхгүй байх эрсдэл байдаг. Тэгвэл клиринг хаус бүрэн хэрэгжсэнээр гүйлгээнүүд багцлагдаж, өдрийн эцэст банкууд төлбөр гүйцэтгэхэд маш их давуу тал бололцоог бий болгох юм. Олон улсад ч төлбөр тооцоо энэ зарчмаар явж ирснийг Монгол Улс ч мөн хэрэгжүүлж эхэллээ.

“Хүн нэг өмөө босоод л
санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди
(Дэлхийн банкны зөвлөх)




ТӨСӨВЧИН Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч,
хадгалагч, зээл тооцоологч, ипотека, төсөвлөгч зэрэг
тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuuginbolovsrol.mn



 /Mongolbank.mn

 /Санхүүгийн боловсрол

 @mongolbank_mn

 www.mongolbank.mn

 /Mongolbankmn

 info@mongolbank.mn

 11 310081